

ТОДОРХОЙ БҮЛГИЙН ХҮҮХДҮҮДЭД БОЛОВСРОЛ ЭЗЭМШИХЭД ТУЛГАРДАГ СААД ТОТГОРУУД

чанарын судалгааны тайлан



UIH.MN
СУДАЛГААНЫ САН



“БҮХ НИЙТ БОЛОВСРОЛЫН ТӨЛӨӨ!”
ИРГЭНИЙ НИЙГМИЙН ҮНДЭСНИЙ ЭВСЭЛ

ТОДОРХОЙ БҮЛГИЙН ХҮҮХДҮҮДЭД БОЛОВСРОЛ ЭЗЭМШИХЭД ТУЛГАРДАГ СААД ТОТГОРУУД

чанарын судалгааны тайлан

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Улаанбаатар
2020 он

Төслийн нэр: Маргиналчлагдсан бүлгийн хүүхдүүдийн боловсрол эзэмшихэд тулгарч буй саад тотгор, бэрхшээлийг тодорхойлох судалгаа

Тайлангийн агуулга: Боловсролоос тусгаарлагдсан хүүхэд, өрхийн нөхцөл байдал, үндсэн шалтгаан, өнөөгийн төлөв байдал, бодлогын суурь асуудлууд

Зөвлөх: Социологийн ухааны доктор М.Батбаатар

Хянасан: Д.Тунгалаг, Я.Мөнхчимэг

Боловсролын төлөө чанга дуугарцгаая! төслийн санхүүжилтийн дэмжлэгтэй хэвлэв

UIH.MN
СЭДАЛГ ААНЫ САН

АГУУЛГА

Өмнөх үг	4
Товчилсон үгсийн тайлбар.....	6
Нэг. Судалгааны зорилго, арга зүй	7
1.1 Судалгааны зорилго, зорилт	7
1.2 Судалгааны түүвэрлэлт, тоо хэмжээ.....	9
1.3 Судалгаанд хэрэглэсэн үндсэн ойлголт, нэр томъёоны тайлбар...	10
1.4 Мэдээлэл боловсруулж, дүн шинжилгээ хийсэн арга, аргачлал ...	12
1.5 Судалгааны зохион байгуулалт	12
Хоёр. Судалгааны үндсэн үр дүн.....	13
2.1 Ядуурал, өрхийн орлого доогуур байдал	15
2.2 Эцэг эхийн хараа хяналт дутагдах	18
2.3 Хүүхдийн хөдөлмөр	21
2.4 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хүртээмж муу байх, тохирох хэрэглэгдэхүүн дутагдах.....	22
2.5 Жендэрт суурилсан хүчирхийлэл	25
2.6 Багшийн тоо, чанар, заах арга зүй.....	26
2.7 Хэл/ үндэс угсаанд суурилсан гадуурхал	26
2.8 Боловсролтой холбоотой төлбөр хураамж	27
2.9 Шилжин суурьшигчдын талаарх үр дүнтэй зохицуулалт сул.....	28
2.10 Дэд бүтэц, тоо, чанар	30
Гурав. Маргиналчлагдсан бүлгийн хүүхдийг боловсролд хамруулах бодлогын асуудлууд.....	31
3.1 Нийгэм-эдийн засгийн статус доогуур/ Эмзэг бүлгийн хүүхдийн боловсрол эзэмшихэд тулгамдаж буй асуудал.....	32
3.2 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын асуудал	34
3.3 Хэл/ соёлын ялгаатай хүүхдийг боловсролд тэгш хамруулах бодлогын асуудал	36
3.4 Жендэрт суурилсан хүчирхийлэл болон үе тэнгийн дарамт, дээрэлхэлтэд өртсөн хүүхдүүдийг боловсролд тэгш хамруулах бодлогын асуудал	38
3.5 Тэгш хамруулах бодлогын бусад асуудлууд	41
Дөрөв. Дүгнэлт, санал.....	46
Тав. Хавсралтууд	49
Хавсралт 1. Баримт бичгийн шинжилгээ хийх аргачлал	49
Хавсралт 2. Мэргэжилтнээс авах стандарт ярилцлагын асуултын чиглэл	51
Хавсралт 3. Хүүхдийн судалгааны асуумж.....	54

ӨМНӨХ ҮГ

“Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвслийн үйл ажиллагааны гол чиглэл нь 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн зорилгуудын хэрэгжилт, ялангуяа боловсролын талаарх Тогтвортой хөгжлийн зорилго 4-ийг Монгол улсад амжилттай хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулах явдал билээ. ТХЗ 4 нь бүх хүүхэд, залуус, насанд хүрэгчдэд насан туршдаа суралцах боломжийг бий болгох, нэн ялангуяа сургуулийн өмнөх ба бага дунд боловсролыг бүх хүүхдийг тэгш хамруулан чанартай эзэмшүүлэх, эрх тэгш байдлыг боловсролын салбарт хангах, хүн бүрийг өөрийн чадавхи потенциалд тултал хөгжих боломжийг салбарын бодлого, төсвөөр бий болгох зорилгыг дэлхий нийтээрээ тавьсан.

Бага боловсролын чиглэлээр хийсэн судалгаанд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, үндэстний цөөнхийн хүүхэд, эмзэг бүлгийн (нийгэм-эдийн засгийн) хүүхэд, малчдын хүүхэд, хүчирхийлэлд өртсөн болон өртөж болзошгүй хүүхэд зэрэг таван бүлгийн хүүхдийг боловсролоос гадуур үлдэх, анхаарлын гадна орхигдох магадлалтай гэж үзсэн байна. Мөн орон нутгаас шилжин ирэгсдийн болон нийтийн байранд хот дотроо нүүдэллэн амьдардаг айлын хүүхдүүдийн боловсролын чанар, хүртээмжийн асуудал гарч ирдгийг онцолсон байна. Тиймээс бид эдгээр бүлгийн хүүхдүүдийн боловсрол эзэмшихэд тулгардаг саад тотгоруудыг судалж, бодлогын зөвлөмжүүдийг олон талын оролцоотой боловсруулан шийдвэр гаргагчдад хүргэхээр энэхүү чанарын судалгааг хийж гүйцэтгэлээ.

Бидний сонгосон ялгаатай хэрэгцээтэй бүлгийн хүүхдүүдийн хувьд тэдний бага боловсролын хамрагдалтын үзүүлэлт болон сурлагын амжилт, чанарыг үндэсний хэмжээнд тусгайлан авч үзсэн баримт, статистик алга байгааг боловсрол судлаачид хэлж байна.

Боловсролын маргиналчлал гэж (1) Монгол Улсад өөр хэл, соёл бүхий угсаатны цөөнхийн хүүхдүүд төрөлх хэлний орчинд олон хэл эзэмших боломжийг дэмжсэн дидактик, оновчтой сургалтын хөтөлбөр одоогоор байхгүй. (2) Үндэсний хэмжээнд албан ёсны статистикаар үндэсний цөөнх, хэл, соёлын ялгаатай бүлгийн хүүхдийн бага боловсролд хамрагдалт болон сурлагын амжилтын үнэлгээг тусгайлан цуглуулсан мэдээлэл олдсонгүй.

(3) Хос хэл болон олон хэлний боловсролын багш нарыг бэлтгэж, тэдний мэргэжлийг дээшлүүлж ирсэн туршлага хомс байна гэж судлаачдын дүгнэлтээр илэрч харагдаж байна. Эдгээр 3 саад тотгор болон бусад эдийн засаг-нийгмийн, соёлын зэрэг бусад саад тотгорын улмаас үндэстний цөөнх казах, тува хүүхдүүдийн СӨБ-д хамрагдалт доогуур, хүүхэд хөгжлийн үзүүлэлт бусад бүлэгтэй харьцуулахад доогуур, бага боловсролд хамрагдалт улсын дунджаас доогуур, сургууль завсардалт өндөр, сурлагын амжилт, ялангуяа ЭЕШ-ын дүн сүүлийн хэдэн арван жилд доогуур байгаа гэсэн үг.

Олон улс оронд маргиналчлагдсан бүлгийн хүүхдүүдэд боловсрол эзэмшихэд тулгарч байгаа саад тотгоруудыг эн тэргүүнд тодорхойлж, тэдгээрийг арилгахыг зорьсон бүлэгт болон хувь хүнд нь чиглэсэн бодлого, төсвийн тусгай тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байж амжилтад хүрсэн жишээ олон байна. Бидний хийсэн чанарын судалгаа болон гарсан зөвлөмжүүдийг бодлого боловсруулахдаа анхааран үзэж, бүх нийтэд заавал эзэмших боловсролыг олгох зорилтоо төр засаг биелүүлэхэд тус дөхөм болно гэдэгт найдаж байна.

Судалгааны мэдээлэл цуглуулахад оролцсон Багануур, Налайх дүүрэг, Өмнөговь аймгийн салбар зөвлөл, Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төв, Өсвөр үе хөгжлийн төв, Хөөрхөн зүрх ТББ, Хүчирхэг хөвгүүд ТББ зэрэг гишүүн байгууллага, Архангай аймгийн Өлзийт, Ховд аймгийн Жаргалант 3, Сүхбаатар аймгийн Баруун-Урт, Мөнххаан, Булган аймгийн Булган, Өвөрхангай аймгийн Арвайхээр, Хужирт, Баян-Өлгий аймгийн Цэнгэл, Буянт сумын СЭЭБХ-үүдэд эвслийн ажлын алба, нийт гишүүдийн өмнөөс талархаж байгаагаа илэрхийлж байна.

Бүх нийт боловсролын төлөө! Иргэний нийгмийн үндэсний эвслийн
Ерөнхий зохицуулагч Д.Тунгалаг

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ТАЙЛБАР

АХБ	Азийн Хөгжлийн Банк
БГД	Баянгол дүүрэг
БЗД	Баянзүрх дүүрэг
БСШУСЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
ГБХЭХГ	Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЕХ	Европын Холбоо
ЖАЙКА	Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага
ИНБ	Иргэний нийгмийн байгууллага
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
НҮБХС	Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүүхдийн сан
ОУБ	Олон улсын байгууллага
СХД	Сонгинохайрхан дүүрэг
СЭЭБҮНХ	Сургуулийн эцэг эх, багшийн үндэсний нэгдсэн холбоо
УИХ	Улсын Их Хурал
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХБХ	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд
ХХИ	Хүний хөгжлийн индекс
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ЭЗХАХБ	Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага
ЭСЗ	Эвслийн салбар зөвлөл
ЮНЕСКО	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага
ЯХИС	Японы Хүүхдийг ивээх сан


ИИМН
СУДАЛГААНЫ САН

НЭГ. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, АРГА ЗҮЙ

1.1 СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Боловсролоос тусгаарлагдсан, эмзэг бүлгийнхний (үндэстний цөөнх, жендэрт суурилсан хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтийн хохирогч хүүхдүүд, алслагдсан сум дүүрэг, хороодын нийгэм эдийн засгийн статусын хувьд эмзэг байдалд байгаа өрхийн хүүхдүүд) боловсрол эзэмшихэд учирч буй саад тотгор, сорилт бэрхшээлийг судлан тодорхойлох, бодлогын зөвлөмж боловсруулахад энэхүү судалгааны зорилго оршино. Судалгааны хамрах хүрээ болон мэдээлэл цуглуулахад хэрэглэсэн арга зүйг схем зураг 1-т харуулав.

Схем зураг 1. Судалгааны арга зүй



Судалгааны мэдээллийг цуглуулахдаа баримт бичгийн шинжилгээ, кейс асуумж, ганцаарчилсан ярилцлагын аргуудыг ашигласан болно.

Хүснэгт 1. Зорилт, арга, судлах зүйл

	Зорилт	Судалгааны арга	Судлах зүйл
1	Холбогдох бодлогын баримт бичиг, статистик мэдээлэлд дүн шинжилгээ хийх	Баримт бичгийн судалгаа*	<ul style="list-style-type: none"> • Маргиналчлагдсан бүлгийн хүүхдэд боловсрол эзэмшихэд тулгарч буй саад тотгор, нөхцөл байдал • Боловсролын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй төрийн байгууллагуудаас (ЕБС-ийн НА, Боловсролын хэлтэс, ГБХЗХГ, гм) зохион байгуулж байгаа үйл ажиллагаа, хэрэгжилт
2	Мэргэжилтэн, шийдвэр гаргагчдаас судалгаа авах	Стандарт ярилцлага**	<ul style="list-style-type: none"> • Мэргэжилтний туршлага, мэдээлэл • Маргинал, эмзэг бүлгийн хүүхдүүд боловсрол эзэмшихэд тулгамдаж буй асуудлын байр суурь • Холбогдох статистик баримт, мэдээ мэдээлэл • Боловсролын хүртээмж, чанарыг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаа
3	ЕБС-ийн IX анги төгсөх сурагчдаас судалгаа авах	Кейс судалгаа*** (Эцэг, эх асран хамгаалагчдаас авах асуумж)	<ul style="list-style-type: none"> • Сурагчдын ерөнхий мэдээлэл, амьдарч буй өрхийн байршил, нөхцөл байдал • Тулгамдаж буй асуудал, үндсэн бэрхшээл • Хэрэгцээ шаардлага • Даван туулах байдал

Судалгааны ажлын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн болно.

Үүнд:

- Судалгааны арга зүй, дизайныг боловсруулах
- Тоон болон чанарын судалгаан мэдээлэл цуглуулах ажлыг талбарт хэрхэн хийх талаар орон нутгийн туслах багт арга зүйн зөвлөгөө, сургалт мэдээлэл өгөх
- Аймаг, дүүргээс цуглуулсан мэдээллийг боловсруулалтын программд шивж оруулах
- Үүссэн мэдээллийн санд үндэслэн дүн шинжилгээ хийх, тайлан бичих

* Статистик мэдээлэл, судалгааны тайлан, хөтөлбөр төлөвлөгөө, хууль эрх, бодлогын баримт бичиг зэрэг хоёрдогч эх сурвалжид дүн шинжилгээ хийх арга юм.

** Шийдвэр гаргах түвшинд ажиллаж буй мэргэжилтний байр суурь, статистик тоо баримт, бодлого үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг цуглуулна.

*** Сурч боловсрох эрх нь зөрчигдөж буй эмзэг бүлгийн хүүхдүүдийн боловсрол эзэмшихэд учирч буй саад тотгор, сорилт бэрхшээлийг эцэг эх, асран хамгаалагчдын ярилцлагад тулгуурлан тодорхойлох арга болно.

1.2 СУДАЛГААНЫ ТҮҮВЭРЛЭЛТ, ТОО ХЭМЖЭЭ

Судалгаа хийх талбараас чанарын болон тоон баримт мэдээллийг гурваас доошгүй мэргэжилтнээс стандарт ярилцлагаар авахаар төлөвлөж байна. Санал асуулгын судалгаанд хамрагдах сурагчид, хүүхдийн тоо хэмжээг тухайн орон нутагт гарч буй кейст тулгуурлан тогтоох ба нэг орон нутгаас ойролцоогоор 5 орчим байхаар төлөвлөсөн. Судалгааны түүвэрлэлтийн тоо хэмжээг Хүснэгт 2-оос үзнэ үү?.

Хүснэгт 2. Түүврийн тоо хэмжээ

Аймаг, нийслэл	Сум, дүүрэг	Стандарт ярилцлагад хамрагдсан мэргэжилтний тоо (ЕБС-ийн НА, Боловсролын хэлтэс, ГБХЗХГ)	Кейс ярилцлагад хамрагдсан хүүхдийн тоо
Баян-өлгий	Цэнгэл сум	2	5
	Буянт	-	2
Өмнөговь	Даланзадгад	4	5
	Гурван тэс	0	2
	Булган	0	1
Ховд	Манхан	---	1
Өвөрхангай	Арвайхээр	3	5
	Хужирт	3	5
Архангай	Өлзийт	---	5
Сүхбаатар	Мөнххаан		7
Булган	Булган	---	4
Улаанбаатар		12	20
Дүүргүүд	Багануур дүүрэг	4	5
	Баянгол дүүрэг	0	2
	Баянзүрх дүүрэг	2	3
	Налайх дүүрэг	2	5
	Сонгинохайрхан дүүрэг	1	4
	Чингэлтэй дүүрэг	3	1
	Нийт		24

Тус судалгаанд нийт 12 аймаг, дөрвөн дүүргийн 80 хүүхэд, 36 экспертийг хамруулахаар төлөвлөсөн боловч цаг үеийн нөхцөл байдалтай холбогдон¹ мэдээлэл цуглуулах талбар хумигдаж 7 аймаг, 6 дүүргийн 60 хүүхэд, 24 экспертийг хамран хийгдсэн байна.

¹ Судалгаа хийх явц COVID 19 цар тахлын хорио цээр болон УИХ-ын сонгуультай давхацсан болно.

1.3 СУДАЛГААНД ХЭРЭГЛЭСЭН ҮНДСЭН ОЙЛГОЛТ, НЭР ТОМЬЕОНЫ ТАЙЛБАР

Маргиналчлагдсан бүлэг. Нийгмийн тэгш бус байдлаас үүдэлтэйгээр урт хугацаанд нийгэм эдийн засгийн статусын хувьд гадуурхагдаж, боловсролын бодлого төлөвлөлтийн хийдлийн улмаас сурч боловсрох эрх нь зөрчигдсөн бүлэг. Энэхүү судалгаанд нийгэм эдийн засгийн статусын хувьд доогуур орлоготой өрхөд амьдарч буй, үндэстний цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй болон жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогч гэсэн дөрвөн бүлгийн хүүхдийг авч үзсэн болно.

Нийгэм, эдийн засгийн статусын хувьд доогуур орлоготой өрхийн хүүхдүүд. Алслагдсан сум дүүрэг, хороодын нийгэм-эдийн засгийн статусын хувьд эмзэг байдалд байгаа амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур² орлоготой өрхөд амьдарч буй хүүхдүүд. Энэхүү судалгаанд дээрх агуулгыг эмзэг бүлгийн, амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой өрхийн хүүхэд зэрэг нэршлээр оруулсан болно. Учир нь судалгаанд хамрагдсан байршил бүр өөр өөрийн нэршлээр мэдээлэл өгч байсан бөгөөд нэгдсэн нэг ойлголт, тодорхойлолт байхгүй нь судалгааны явцад харагдсан.

Үндэстний цөөнх бол тухайн улсад зонхилох байр суурь эзэлдэггүй бөгөөд тодорхой үндэстэн, угсаатан, шашин шүтлэг, эсвэл хэлний хувьд олонх хүн амаас ялгардаг хувь хүмүүс юм. (*UNCHR, Fact sheet no18, Minority rights*)

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд гэдэгт бие мах бодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан, 18 нас хүрээгүй хүн бүрийг (*Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай. МУ-ын хууль. 4.1.1, Хүүхдийн эрхийн тухай конвенц*)

Жендэрт суурилсан хүчирхийлэл гэж жендэрээс үүдэлтэйгээр бусдад бие мах бодийн, бэлгийн, сэтгэл санааны гэм хор, эдийн хохирол учруулсан, учруулж болзошгүй үйлдэл, эс үйлдэхгүйг хэлнэ. (*Жендэрийн тэгш байдлыг хангах тухай. МУ-ын хууль. 4.1.8*)

Үе тэнгийн дарамт дээрэлхэлт-д жендэрт суурилсан хүчирхийллийн хэлбэрүүд, нийгмийн гарал үүсэл, статусаас хамааран ялгаварлах, гадуурхах, шоглох, заналхийлэх, цохих, тохуурхах, эд зүйлийг нь хулгайлах шууд үйлдэл болон нэгнийхээ талаар бусдад мэдэгдэхийг хүсдэггүй нууц болон худал, үндэслэлгүй цуу яриа тарааж тухайн сурагчийг нийгмээс тусгаарлагдахад нөлөөлөх шууд бус үйлдлүүд орно.

Гадуурхах гэдэгт шууд болон шууд бусаар ямар нэгэн хэлбэрийн боловсрол эзэмшүүлэхээс татгалзах эсвэл элсүүлэхгүй байхыг ойлгоно.

Тусгаарлан сургах гэдэг нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдыг тэдний тодорхой нэг согог эсвэл хэд хэдэн төрөл хавсарсан согогт хариу үйлдэл үзүүлэх байдлаар зохион байгуулсан тусгай орчинд хөгжлийн бэрхшээлтэй

2 Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох тухай хууль. 5-р зүйл. УИХ.1998. Хэрэглээний доод хэмжээг тогтоосон түвшин Улаанбаатар-230.0, Хангайн бүс-206.0, Баруун бүс-203.4, Зүүн бүс-201.7, Төвийн бүс-198.3 мянган төгрөгөөр 2020 онд ҮСХ-ноос шинэчлэн тогтоосон.

суралцагчдаас тусад нь боловсрол олгохыг хэлнэ.

Нэгтгэн сургах гэдэгт нийтэд зориулсан боловсролын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй хүнийг стандартчилсан шаардлагад нийцэн сурч чадна гэж үзэн байршуулахыг ойлгоно.³

Тэгш хамруулан сургах гэдэгт тухайн насны бүх суралцагчдыг эрх тэгшээр хамтдаа суралцах туршлагатай болгож, тэдний давуу тал болон тавигдах шаардлагад хамгийн дээд зэргээр тохирсон орчинг бий болгож үйлчилнэ гэсэн алсын харааг хэрэгжүүлэхэд учрах саад тотгорыг даван туулахын тулд боловсролын агуулга, заах арга, хандлага-арга зүй, бүтэц, стратегидаа тодруулга өөрчлөлт, цогц өөрчлөлт оруулах замаар тогтолцооны шинэчлэл хийх үйл явцыг багтаана.

Тэгш хамруулах боловсрол (inclusive education) нь бүх суралцагчдын нийгэм, соёл, боловсролын үйл ажиллагаан дахь тэгш оролцоог хангах, боловсролын гаднах болон доторх бүх хэлбэрийн ялгаварлан гадуурхалтыг бууруулах замаар сурагч бүрийн ялгаатай хэрэгцээнд нийцүүлэн боловсролын үйлчилгээг хүргэх үйл явц мөн. Суралцагсдын харилцан адилгүй байдал, ялгаатай хэрэгцээ, хэл соёл, нийгмийн гарал, эдийн засгийн хүчин зүйлсээс үл хамааран хүн бүрийн мэдлэг чадвараа дээшлүүлэх, боловсрол эзэмших тэгш боломж болон эрхийг хангахад чиглэсэн үйл явц юм. (*ЮНЕСКО-ийн Монголын Үндэсний комисс, 2014*).

Тэгш хамруулан сургах боловсрол нь суралцагч бүрийг эрх эдлэгч гэж үздэг, тэднийг сургуулийн нэгэн булангаас анхаарлын төвд авчирдаг. Энэ нь хувь хүний бэрхшээлээс илүү нийгмийн нөхцөл байдалд анхаарлыг шилжүүлж байгаа хэрэг юм. Тэгш хамруулан сургах тогтолцоо нь хүүхэд боловсролын тогтолцоонд зохицохоос илүү боловсролын тогтолцоо хүүхдэд зохицохыг баталгаажуулахын тулд боловсрол, орон нутгийн, бүлгийн өөрчлөлтийг дэмждэг. Тэгш хамруулан сургах тогтолцоо нь хувь сурагчдын ялгаатай хэрэгцээнд тохируулах, тэр боломжид саад болж байгаа саад тотгорыг арилгахын тулд сургууль дахь **соёл, бодлого, практик үйл ажиллагааг** өөрчлөн зохион байгуулах шаардлагыг хүлээн зөвшөөрдөг.⁴



3 А/HRC/25/29Corr.1-ийн 4-р догол мөр болон НҮБ-ын Хүүхдийн сан (НҮБХС), Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох эрх: Тэгш хамруулах боловсролд хүний эрхэд суурилан хандах нь (Женев хот, 2012)

4 “Тэгш хамруулах боловсрол мэдээллийн багц” 2014 он, “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвсэл

1.4 МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛЖ, ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН АРГА, АРГАЧЛАЛ

Энэхүү судалгааны хүрээнд хүүхэд, өрхөөс авсан асуумжийн тоон мэдээллийг EXCEL программ дээр шивж, анхдагч мэдээллийн сан үүсгэсэн. Мэдээлэл боловсруулах SPSS 23.0 программ ашиглан тоон мэдээллийг боловсруулсан бөгөөд анхан шатны харьцуулалт хийж, хүснэгт графикаар илэрхийлэв. Боловсролын салбарын экспертүүдээс ярилцлагын аргаар авсан чанарын мэдээлэлд дүн шинжилгээ хийхдээ харьцуулалт, зураглал, логик дүн шинжилгээг хийсэн болно.

1.5 СУДАЛГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Судалгааны зорилго, судлах асуудал, хамрах хүрээ хязгаарыг 2020 оны 03 сард “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвслийн төслийн багтай ярилцаж тодорхойлсон. Хүүхдээс авах кейс асуулгыг судалгааны зөвлөх боловсруулж, төслийн баг болон мэргэжилтнүүдийн зөвлөмжийг авч эцэслэсэн болно. Түүнчлэн бэлтгэл ажлын хүрээнд төслийн баг талбарт ажиллах орон нутгийн судлаачдад зориулсан хагас өдрийн цахим сургалтыг зохион байгуулж, төсөл болон судалгааны талаарх ойлголт, маргиналчлагдсан бүлгийн хүүхэд, хүүхдийн хүчирхийллийн төрөл, хэлбэрийн талаар тайлбарлаж, гол тодорхойлолт болон мэдээлэл цуглуулахтай холбогдох ёс зүйн дүрэм журмыг зааж мэдлэг, ур чадвар олгосон.

Судалгааны мэдээлэл цуглуулалтыг 2020 оны 04-р сарын 20-оос 05-р сарын 20-ны хооронд хийж, мэдээллийг нэгтгэх, үр дүнг шинжлэх, судалгааны тайлан боловсруулах, хянаж сайжруулах, эцэслэх ажлыг 2020 оны 06 сард хийж гүйцэтгэлээ.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ХОЁР. СУДАЛГААНЫ ҮНДСЭН ҮР ДҮН

Судалгааны үндсэн үр дүнг хүүхдийн тохиолдол шинжлэх судалгааны мэдээлэлд тулгуурлан нэгтгэн дүгнэсэн болно. Тухайн судалгаанд нийт 7 аймгийн 11 талбар, нийслэлийн 6 дүүргээс 60 хүүхдийн нөхцөл байдлыг кейс болгон судалж, 24 мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагыг судалгааны үр дүнг бэлтгэхэд эх сурвалж болгон ашиглалаа. Судалгаанд хүүхдийг хамруулахдаа өрхийн нөхцөл байдал, хүүхдийн суралцах боломж, нөхцөлийг тодорхойлж байдаг үндэслэн тухайн хүүхдийн амьдарч буй өрхийн суурь мэдээллийг авч үзсэн болно. Өрхийн мэдээлэлд ам бүлийн тоо, эцэг эхийн ажил эрхлэлтийн байдал, өрхийн сарын дундаж орлого болон нэг хүнд оногдох дундаж мөнгөн орлого зэргийг авч үзсэн.

Судалгаанд оролцсон хүүхдүүдэд суралцах, боловсрол эзэмшихэд саад болж буй хүчин зүйлсийг дараах байдлаар үнэлсэн байна. Судалгаанд хамрагдсан хүүхдийн хариултыг маш сайн-5, сайн-4, дунд-3, тааруу-2, маш муу-1 гэсэн таван түвшинт Лайкертийн шкалаар үнэлүүлж, дундаж утгыг тооцож, эрэмбэлсэн болно.

Хүснэгт 3. Таны бодлоор Хүүхдийн суралцах, боловсрол эзэмшихэд юу саад болж байна вэ?

		N	Доод утга	Дээд утга	Дундаж утга	Хэлбэлзэл
1	Мөнгө санхүүгийн бэрхшээл	48	1	5	3.60	1.34
2	Ядуурал, амьжиргааны түвшний дорой байдал	43	1	5	3.46	1.40
3	Тусгай хэрэгцээ /хөгжлийн бэрхшээл/	34	1	5	3.26	1.81
4	Хэл, соёлын бэрхшээл	37	1	5	2.86	1.47
5	Гэрийн ажил (дүүгээ харах, газар тариалан, өрхийн үйлдвэрлэлд туслах гм)	37	1	5	2.38	1.52
6	Ялгаварлан гадуурхал	39	1	5	2.28	1.55
7	Жендэрт суурилсан хүчирхийлэл	37	1	5	2.27	1.63
8	Байршил, алслагдсан байдал	36	1	5	2.33	1.45
9	Мал маллах	33	1	5	1.97	1.31
10	Ажил хөдөлмөр эрхлэх	31	1	5	1.65	1.17
11	Хурдан морь унах/унаач хийх	32	1	4	1.44	0.91
12	Өөр ямар: үл хайхрах, хараа хяналтгүй байдал, ой тогтоолт, ярих чадвар гм	16	1	5	3.50	1.83

Өнөөгийн хүүхдийн суралцах, боловсрол эзэмшихэд мөнгө санхүүгийн бэрхшээл (3.60), ядуурал, амьжиргааны түвшний дорой байдал (3.46) ихээхэн нөлөөлж байгааг хүснэгтээс харж болох юм. Хүснэгтэд эрэмбэлсэн мэдээллээс үзэхэд хүүхдийн суралцах, боловсрол эзэмшихэд нөлөөлдөг дараагийн бүлэг гурван хүчин зүйлсэд хэл, соёлын бэрхшээл (2.86), гэрийн ажил, хөдөлмөр (2.38), ялгаварлан гадуурхал (2.28) зэрэг багтаж байна. Эдгээрийн зэрэгцээ жендэрт суурилсан хүчирхийлэл, байршил, алслагдсан байдал, эцэг эх, асран хамгаалагчдын зүгээс хүүхдээ мал маллуулах сонирхол зэрэг хүчин зүйлс хүүхдийн суралцах, боловсрол эзэмшихэд тодорхой хэмжээгээр нөлөөлж байгаа болно.

Энэ судалгаа Монголын боловсролын эзэмшихэд тулгарч байгаа саад тотгоруудыг эрэлт, нийлүүлэлт ба засаглалын талаас авч үзсэн. Эрэлт талын саад тотгорууд нь сургуулийн насны хүн амын зүгээс хангалтгүй хэмжээний эрэлт үүсэж байгааг илэрхийлдэг. Үүнд нийгэм-соёлын ба эдийн засгийн саад тотгорууд багтана. Жишээлбэл, сургуулийн насны охид жирэмслэх, мөн хүчирхийлэл, дарамт, үе тэнгийн дээрэлхэлтээс үүдэлтэй хөвгүүд боловсрол эзэмшихэд саад учирдаг нь соёл, түүнтэй холбоотой итгэл үнэмшил, сургуулийн өдөр тутмын хэвшсэн практик үйл ажиллагаатай холбоотой байдаг. Мөн ядуурал, хүүхдэд тавих анхаарал халамж сул байх зэрэг багтах ба хүүхдээ сургуульд явуулж хүчрэхгүй эсвэл хүүхдээ тогтмол сургуульд явуулах шаардлагыг биелүүлдэггүй эцэг эх байх жишээтэй.

Нийлүүлэлт талын саад тотгорууд нь санал болгож байгаа боловсролын боломжууд дутагдалтай байхыг илэрхийлэх ба үүнээс үүдэлтэйгээр сургуульд сурахад учрах бэрхшээлүүд юм. Тухайлбал, энэ тохиолдолд малчдын хүүхдэд олгох боловсролын асуудал, сургуулийн өмнөх боловсролыг бүгдэд хүртээмжтэй болгох зэрэг асуудлууд хөндөгддөг. Сургалтын агуулгын нийцэл, багш бэлтгэгдсэн чанар, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд нэмэлт дэмжлэг үйлчилгээ дутагдах зэрэг саадууд багтана.

Улс төр, засаглал, чадавх ба санхүүгийн саад тотгорууд нь ялангуяа төр талаас дэмжсэн орчинг бий болгоогүй байгаатай холбоотой сорилт бэрхшээлүүдийг агуулдаг. Үүнд боловсролын статистик гаргах чадавх, төсвийн дутагдал, санхүүгийн алдаа дутагдал зэрэг багтана. Тухайлбал, сургууль завсардсан болон завсардах эрсдэлтэй хүүхдүүдийг хянах, хамран сургалтыг хэмжих боломжгүй бол төлөвлөлт, бодлого шийдвэр гаргах үйл явцыг ээдрээтэй болгоно.

Боловсрол эзэмшихэд тулгарч буй саад тотгорыг бид дараах байдлаар ангилж үзлээ. Үүнд:

ТӨРӨЛ	УЧИРЧ БАЙГАА СААД ТОТГОРУУД
Эрэлт талын, нийгэм-соёлын	Нийгмийн хүлээлт, жендэр ба боловсрол
	Хэл/үндэс угсаанд суурилсан гадуурхал
	Хүчирхийлэл /дарамт, үе тэнгийн дээрэлхэл
Эрэлт талын, эдийн засгийн	Ядуурал/ өрхийн орлого доогуур байх
	Эцэг эхийн хараа хяналт дутагдах
	Хүүхдийн хөдөлмөр
	Нэмэлт зардлууд

Нийлүүлэлт талын	Нүүдэлчин амьдралын хэв маягт тохирсон боловсрол олгож чадахгүй байх
	Шилжин суурьшигчдын талаарх үр дүнтэй зохицуулалт сул
	Багшийн тоо/ чанар ба заах арга зүй
	Сургалтын хөтөлбөрийн агуулга
	Дэд бүтцийн тоо/ чанар
	Нас хэтэрсэн хүүхдийг доромжлон гутаах
Улс төр-засаглал, чадавч ба санхүүгийн саад тотгорууд	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хүртээмжгүй, тохирох хэрэглэгдэхүүн дутагдах
	Боловсролын статистик, өгөгдөл найдваргүй байх Салбарын төсвийн хомсдол / сул удирдлага

Эдгээр саад тотгорууд тус тусдаа үзэгдэл биш бие биенээсээ хамааралтай ба эдгээрийг арилгахын тулд хосолмол шийдлүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Мөн түүнчлэн эдгээр саад тотгорууд боловсролд нөлөөлдөг ч боловсролын салбарт бүгд хамаатай биш төдийгүй салбар дангаараа шийдэх боломжгүй. Боловсролын шууд бус зардлууд хичээлийн хэрэглэл, дүрэмт хувцас, унаа, хоолны зардал нь нийгэм эдийн засгийн хувьд статус доогуур гэр бүлийн хувьд хүүхдийнхээ боловсролын зардлыг хүчрэх аргагүй болгодог. Сургуульд байгаа хүүхдийнхээ шууд бус зардлыг төлж чадахгүй тохиолдолд хүүхэд үе тэнгийнхнээсээ ичих, дээр нь нэмээд багш нар хичээлийн бэлтгэлгүй ирлээ хэмээн буруутгах, шийтгэх нэмэгдвэл нийгэм-соёлын саад нэмэгдэж сургуулиас гарахад хүргэдэг гэсэн үг. Насан туршийн боловсролын байгууллагын судалгаагаар хамгийн ядуу бүлгийн хүүхдүүд сургуулиас гадуур байгааг баталсан.¹

2.1 ЯДУУРАЛ, ӨРХИЙН ОРЛОГО ДООГУУР БАЙДАЛ

Боловсрол эзэмшихэд тулгарч буй саад тотгорын тэргүүнд ядуурал, амьжиргааны дорой байдал орж байгаа нь бусад судалгаагаар² ил болсон бөгөөд энэхүү судалгаагаар ч мөн тодорхой гарсан.

Судалгаанд хамрагдсан 60 хүүхдийн амьдарч буй өрхийн ам бүлийн дундаж тоог авч үзэхэд ойролцоогоор дөрөв, хамгийн олон гишүүнтэй өрх 8 хүртэл ам бүлтэй байна. Харин өрхийн сарын дундаж орлого 706.090 төгрөг байгаа бол хамгийн бага орлоготой өрх хүүхдийн тэтгэмжийн 20 мянган төгрөгөөр амьжиргаагаа залгуулдаг байна. Нэг хүнд ногдох дундаж мөнгөн орлогыг авч үзэхэд ойролцоогоор 155 мянга орчим төгрөг байгааг хүснэгтээс харж болох юм.

1 Насан туршийн боловсролын дэд салбарын судалгааны тайлан, БСШУЯ, 2019 он
2 “Ядуурлын дүр төрх” тайлан, ҮСХ, 2018 он

Хүснэгт 4. Өрхийн хүн ам, амьжиргааны дундаж үзүүлэлт

	N	Доод утга	Дээд утга	Дундаж утга	Ст.хазайлт
Өрхийн ам бүлийн тоо	60	2.00	8.00	4.9167	1.52150
Нэг хүнд ногдох орлого	55	5000.00	666666.67	154853.6797	153624.07267
Өрхийн сарын дундаж орлого	55	20000.00	3000000.00	706090.9091	693940.49998

Өөрөөр хэлбэл, өрхийн сарын дундаж орлогыг ам бүлийн тоонд харьцуулан нэг хүнд ногдох сарын дундаж орлогыг тооцож үзэхэд судалгаанд хамрагдсан өрхийн 70 гаруй хувь нь нэг хүнд оногдох дундаж орлогын хувьд “Хүн амын амьжиргааны доод түвшин”-ээс доогуур³ орлоготой байна. Өрхийн орлогод цалин орлогоос илүүтэй хамаатан садны дэмжлэг туслалцаа өндөр хувьтай байгаа нь эдийн засгийн хувьд судалгаанд хамрагдсан өрхүүд эмзэг нөхцөлд байгааг харуулж байна. Өрхийн орлогын эх үүсвэрийг чухам юу бүрдүүлж байгаа талаар тодорхойлоход дараах онцлог харагдаж байна.

Хүснэгт 5. Өрхийн орлогын эх үүсвэр

	Хариулт	
	Тоо	Хувь
Цалин	29	25.2%
Түрээсийн ашиг	1	0.9%
Бизнес, наймааны орлого	3	2.6%
Өрхийн аж ахуй/мал, ногоо, туслах аж ахуй/	12	10.4%
Зээлдүүлсэн болон хадгаламжийн хүүгийн орлого	2	1.7%
Мөнгөн тусламж/гадаадаас гуйвуулсан	26	22.6%
Тэтгэвэр тэтгэмж/хүнсний талон/	3	2.6%
Хамаатан садны дэмжлэг туслалцаа	37	32.2%
Хүүхдийн тэтгэмж, хүүхдийн мөнгө	2	1.7%
Нийт	115	100.0%

Судалгаанд хамрагдсан өрхийн тоон үзүүлэлтийг бүлэглэж дараах хүснэгтэд харуулав. Өрхийн хувьд 4-6 ам бүлтэй өрх зонхилж байна. Өрхийн орлогыг сарын дундаж орлогод тулгуурлан бүлэглэж үзэхэд 800 мянга хүртэлх орлоготой өрх, нийт өрхийн 76.4 хувийг эзэлж байна.

3 Монгол Улсын ҮСХ-ны даргын тушаалаар 2020.01.13-ны өдрийн А/05 тоот тушаалын хавсралтад дурдсанаар Улаанбаатар хотын нэг хүнд сард ногдох ХААДТ-г 230,000 төгрөг, Хангайн бүс-206000, Баруун бүс-203400, Зүүн бүс-201700, Төвийн бүс-198300 төгрөг байхаар тус тус тогтоосон.

Хүснэгт 6. Судалгаанд хамрагдсан өрхийн ерөнхий мэдээлэл

		Давтамж	Хувь	
1	Өрхийн ам бүлийн тоо	2 ам бүлтэй	4	6.7
		3 ам бүлтэй	7	11.7
		4 ам бүлтэй	12	20.0
		5 ам бүлтэй	15	25.0
		6 ам бүлтэй	14	23.3
		7 ам бүлтэй	5	8.3
		8 ам бүлтэй	3	5.0
		Нийт	60	100.0
3	Өрхийн орлогын бүлэг	200.0 мянган төгрөг хүртэл	9	15.0
		201-400 мянган төгрөг хүртэл	17	28.3
		401-600 мянган төгрөг хүртэл	10	16.7
		601-800 мянган төгрөг хүртэл	6	10.0
		801- 1.0 сая төгрөг хүртэл	3	5.0
		1.0 сая төгрөгөөс дээш	10	16.7
		Хариулаагүй	5	8.3
		Нийт	60	100.0

Өрхийн орлогыг бүлэглэн хувьд авч үзэхэд 1.0 сая төгрөг хүртэлх орлоготой өрх 81.8 хувийг эзэлж байгаа бол түүнээс дээш орлоготой өрх үлдсэн 16.7 хувийг эзэлж байна. Орлогын эх үүсвэрийн хувьд цалин хөлс (үүнд, гар урлал, өрхийн аж ахуй зэрэг жижиг дунд бизнесийн орлогоос гадна туслах ажилтан, барилгын ажил зэрэг өдрөөр цалинждаг ажил эрхэлдэг гэсэн бөгөөд тухайн ажлууд нь улирлын чанартай, байнгын биш, баталгаагүй, тогтвортой бус ажлын байрууд байна.), тэтгэмж (тэжээгчээ алдсаны тэтгэмж, группын мөнгө, хүүхдийн мөнгө, тэтгэвэр зэрэг) –ээр амьжиргаагаа залгуулдаг айл өрх дийлэнх нь байв.

Судалгаанд хамрагдсан өрхийн бараг 80 орчим хувь нь амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур, орлогын хувьд эмзэг, ядуу нөхцөлд амьдарч байна. Өрхийн байршил, орчныг авч үзэхэд хотын захын гэр хороолол болон аймгийн төвөөс алслагдсан газар байрлаж буй өрхөд амьдарч буй хүүхэд гэрээсээ, өөрийн сурдаг сургууль хүртэл, 2 автобус дамжих (аймгийн төвд автобус явдаггүй), 2-3 гэрлэн дохио гарах, гэрийн орчинд шинэ замын засвар, сайжруулсан суваг шуудуу, тоосгоны үйлдвэр, хогийн цэг, нийтийн үйлчилгээний газар, согтуу хүн, эзэнгүй ноход зэрэг эрсдэлт орчин, нөхцөл байна. Мөн сумын төв, багийн сургуулиас алслагдсан газар амьдардаг малчин өрхийн хүүхдүүд сургуульд бүрэн хамрагдаж чадахгүй байгаа нь судлаачдын анхаарал татаж байв.

Судалгаанд хамрагдсан зарим өрхийн хувьд ажил хөдөлмөр эрхэлдэггүй бөгөөд хүүхдийнхээ сургуульд суралцах хэрэгцээг бүрэн гүйцэд хангаж чаддаггүй, хүүхдийн мөнгөөр амьдралаа залгуулдаг. Энэ нь хүүхэд сургуульдаа сурах хүсэл сонирхолгүй болоход нөлөөлж буйгаа дурджээ. Жишээ нь, "Охин

маань суралцах хүсэл сонирхол багатай байдаг нь манай амьдралын түвшнээс болдог” гэжээ. Хүүхэд хувцас хунар, хичээлийн хэрэгсэл муутай, сургуульд суралцахад өмсөх хувцас тааруугаас үе тэнгийнхэн болон найзуудаасаа ичиж, хичээлдээ явахгүй байх хоёр тохиолдол гарсан байна. Нэг өрхөөс 2-3 хүүхэд сургуульд зэрэг сурдаг болохоор дүрэмт хувцасны асуудал хүнд тусдаг, уван цувуулаад боломжоороо авч өгдөг. Гэхдээ дүрэмт хувцас хүрэлцэхгүй (ах, эгчийнхээ эсвэл дүүгийнхээ хувцсыг ээлжилж өмсдөг) тохиолдолд дүрэмт хувцасгүй сургууль дээр очсоноор багш, сургуулийн удирдлагад загнуулах, бусдын өмнө эвгүй байдалд орохоос эмээж, дүрэмт хувцасгүй үедээ хичээлдээ очдоггүй гэжээ. Мөн нийгэм, эдийн засгийн хувьд эмзэг бүлгийн өрхөд амьдарч буй хүүхдүүдийн хувьд хоолны мөнгө байхгүй, өлөн зэлмэн байх үе олонтаа тохиолдож байна.

Энэхүү судалгаа нь өрхийн ядуурлыг хэмжих, нөгөө талаас боловсролд тэгш хамруулах талаар тусгайлан судлах зорилго агуулаагүй, бусад судалгааны хүрээнд эдгээр асуудлыг судалсан. Үндэсний Статистикийн Хорооноос 2018 онд гаргасан Өрхийн нийгэм эдийн засгийн судалгааны “Ядуурлын дүр төрх”⁴ тайлангаас үзэхэд өрхийн түвшинд 0-14 насны гурав ба түүнээс дээш хүүхэдтэй өрхүүд илүү ядуу амьдарч байгааг, нийт ядуу хүн амын 42 хувь нь 15 хүртэлх насны хүүхдүүд байгааг тус тус онцлон дурджээ. Түүнчлэн 30-39 насны, залуу өрхийн тэргүүнтэй, олон хүүхэдтэй өрхүүд ядууралд илүү өртөмтгий байгаа нь илэрсэн ба өнөөгийн хүүхдийн суралцах, боловсрол эзэмшихэд мөнгө санхүүгийн бэрхшээл (3.60), ядуурал, амьжиргааны түвшний дорой байдал (3.46) ихээхэн нөлөөлж байгааг энэ судалгаанаас харж болохоор байна.

2.2 ЭЦЭГ ЭХИЙН ХАРАА ХЯНАЛТ ДУТАГДАХ

Судалгаанд хамрагдсан хүүхдүүд сургуульд суралцдаг эсэх, нас, хүйсийн онцлог, оршин ахуйн нөхцөл байдлыг энэхүү кейс судалгааны хүрээнд авч үзлээ. Хүүхдүүдийг хүйсийн хувьд авч үзэхэд 53.3 хувь нь эмэгтэй хүүхэд, 46.7 хувь нь эрэгтэй хүүхдүүд байна. Судалгаанд 12-15 насны хүүхдүүд бусад насны хүүхдүүдээс өндөр хувиар хамрагдсан бөгөөд судалгаанд хамрагдсан нийт хүүхдүүдийн 43.3 хувь болох юм.

Хүснэгт 7. Судалгаанд хамрагдсан хүүхдийн нийгэм, хүн ам зүйн мэдээлэл

№	Үзүүлэлт		Давтамж	Хувь
1	Хүйс	Эмэгтэй	32	53.3
		Эрэгтэй	28	46.7
		Нийт	60	100.0

4 “Ядуурлын дүр төрх” тайлан, ҮСХ, 2018 он, 35 дахь тал

2	Нас	11 хүртэл настай	19	31.7
		12-15 настай	26	43.3
		16-18 хүртэлх настай	15	25.0
		Нийт	60	100.0
3	Одоо сургуульд сурдаг бол хэддүгээр анги вэ?	Бага анги(1-5)	13	21.7
		Дунд анги(6-9)	19	31.7
		Ахлах анги(10-12)	4	6.7
		Сургуульд суралцдаггүй	24	40.0
		Нийт	60	100.0
4	Эцэг эхийн хамт амьдардаг эсэх?	Эцэг эхийн хамт амьдардаг	48	80.0
		Эцэг эхийн хамт амьдардаггүй	12	20.0
		Нийт	60	100.0
5	Айлын хэд дэх хүүхэд вэ?	Айлын том хүүхэд	24	40.0
		Айлын дунд хүүхэд	21	35.0
		Айлын бага хүүхэд	13	21.7
		Айлын ганц хүүхэд	2	3.3
		Нийт	60	100.0

Үүнээс үзэхэд судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 80 хувь буюу 48 нь эцэг эхийн хамт амьдардаг бол үлдсэн 20 хувь буюу 12 нь эцэг эхээсээ тусдаа амьдардаг ажээ. Эцэг эхээс тусдаа амьдарч буй 12 хүүхдийг хаана, хэнтэй амьдардаг талаар асуухад 3 нь өвөө, эмээгийн дээ, 2 нь ах дүү, хамаатан садныдаа, 2 нь танил айлд, 5 нь эмээ, өвөө, өөрийн хүүхэдтэйгээ бусад газар болох айлын хашаа, нийтийн байр болон түр хамгаалах байранд амьдарч байгаа гэсэн хариулт өгчээ. Сургуульд суралцахад бэрхшээлтэй, завсардсан хүүхдүүд айлын хэд дэх хүүхэд болох талаар сонирхоход 40.0 хувь нь айлын том хүүхэд, 35.0 хувь нь айлын дунд хүүхэд байгаа бол 21.7 хувь нь айлын бага хүүхэд байв. Эдгээр хүүхдүүд дунд айлын ганц хүүхэд харьцангуй бага 3.3 хувийг эзэлж байна.

ТОХИОЛДОЛ 1

Д нь 4 билүү 5 настайдаа аав ээж хоёр нь салаад манайд ирсэн. Одоо 7 жил болж байгаа. Ирснээсээ хойш ээжийгээ хараагүй учир царайг нь мартчихсан байх. Сургуульд оруулах гээд ээжээс нь бичиг баримтыг авах гэсэн боловч өгөөгүй. Хүүхдийн мөнгийг нь авах гээд өгөхгүй байгаа гэж бодож байна. Аав нь манай хамаатан ч орон гэргүй айл, айл дамжин амьдардаг. Би 2019 онд сумын хүүхэд хамгааллын багт хүсэлт тавьж түр асран хамгаалагч нь болсон. Албан бус боловсролын төвд явуулж дөрвөн аргын тоо, уншиж бичиж сургана гэж бодож байгаа. Цаашдаа малчин болох байх.

Эцэг эхийн анхаарал, дэмжлэг сул, хүүхдээ сургах сонирхолгүй тохиолдол. Хүүхэд суралцах, боловсрол эзэмшихэд эцэг эхийн дэмжлэг, хайр халамж нэн чухал бөгөөд харамсалтай нь судалгаанд оролцсон ихэнх хүүхдүүдийн хувьд хайр халамж, хоол хүнс, хувцас хунаргүй үл хайхрах хүчирхийлэлд өртөж, хараа хяналтгүйн улмаас сургуульдаа явж чадахгүй, алхам тутамд өлсөх, даарах, ялгаварлагдах бэрхшээлтэй тулгарсны улмаас боловсролоос хөндийрөх тохиолдол нийтлэг байна.

ТОХИОЛДОЛ 2

Түүнийг Б гэдэг. 1999 онд төрсөн. Одоо 21 настай. Эцэг эхийн хамт амьдардаг. Айлын дунд хүүхэд. Өрхийн байршил сумын төвөөс алслагдсан, амьжиргааны түвшин доогуур, эцэг эх, сургуулийн хайхрамжгүй байдлаас шалтгаалан насандаа сургуульд орж чадаагүй. 13 настайдаа анх 1-р ангид орж 5-р анги төгсөөд сургуулиас гарсан. Учир ангийнхнаасаа насаар ахмад, бие томтой байснаас “өндөр, гозон тэмээ” гэхчлэн хочлон шоолдог байсан нь өөртөө итгэлгүй, сурах хүсэл сонирхолгүй болоход нөлөөлж сургууль завсардсан.

Эцэг эх архины хамааралтай тохиолдол. Хүүхдийн сурч боловсрох хэрэгцээ төдийгүй хүүхдийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж байна. Архидалт, хэрүүл зодоон, хараа хяналтгүй байдал зэрэг нь хүүхдийг тайван амгалан орчинд амьдрах хэрэгцээг алдагдуулж, айдас бий болгож, эцэг эхдээ дургүйцэх нөхцөл болж улмаар гэрээсээ дайжихад хүргэдэг байна.

ТОХИОЛДОЛ 3

4-р ангийн сурагч Б нь охин дүүгийн хамт хойд эцэг Ш-тэй хамт сумын төвд амьдардаг. Ээж нь ажил хийхийн тулд гэрээсээ хол байдаг. Судлаачдыг гэрт нь очиход хойд эцэг нь согтуугаар машин жолоодож яваад цагдаад баригдан аймгийн төв рүү явсан байдалтай байв. Тэд одоогийн байдлаар гэртээ насанд хүрсэн харгалзах хүнгүй, хараа хяналтгүй байгаа. “Хойд эцэг нь гэртээ байнга архи ууж, ээжтэй нь хэрэлдэх үед гэртээ байж суухын аргагүй болдог. Ээжийг байхгүйд хааяа зоддог ч, ээжийнхээ санааг зовооно гээд хэлдэггүй” тухайгаа Б судлаачдад ярьсан. Гэр нь сургуулиас хол болохоор хааяа хичээлээ тасалдаг. Тэрээр хэлэхдээ “саяхан аав согтуу ирээд ээж, дүү бид гурвыг хөөгөөд явуулсан. Бид нар ээжийн ахынд очиж хоноод маргааш нь хөдөө эгчийнх рүү явж байсан боловч, хойд аав цагдаад баригдсан гээд ээж, бид хоёрыг сумын төв рүү явуулсан” гэжээ.

Эцэг эх нь салсан, хүүхэд эцэг эхээс тусдаа амьдарч байгаа тохиолдолд хараа хяналтгүй болж насанд хүрэгчдийн хүүхдэд тавих анхаарал халамж суларч жендэрт суурилсан хүчирхийлэлд өртөх, үл хайхрах хүчирхийллийн хохирогч болох зэрэг эрсдэлт нөхцөлд хүүхэд боловсрол, сургуулиас хөндийрч, тусгаарлагдах тохиолдол ажиглагдаж байна.


ТОХИОЛДОЛ 4

Архины хамааралтай ээжийгээ асрах зорилгоор эгч нь нэг жил сургууль завсардаад, дүүгээ 9-р анги төгсөхөд нь 2-уулаа зэрэг коллежид элссэн. Хичээлийн бус цагаараа ээлжлэн ээжийгээ асардаг. Охидын ээж 2 жилийн өмнө гэр бүлийн хүнээ алдсанаас үүдэн архины хамааралтай болсон. Өрхийн орлого хүүхдийн мөнгө, тэжээгчээ алдсаны тэтгэмж, хамаатан садны дэмжлэгээр түрээсийн хашаанд амьдардаг.

2.3 ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨР

Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 60.0 хувь нь аль нэг түвшний сургуульд суралцдаг бол 40.0 хувь нь завсардсан буюу сургуульд суралцдаггүй гэж хариулсан байна. Өрхийн амин зуулгад нэмэр болох зорилгоор хүүхэд хөдөлмөр эрхлэх нь хичээл, сургуулиас хөндийрөх үндсэн шалтгаан болдог. Судалгааны үр дүнгээс үзэхэд нийт судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 12 хувь нь буюу 7 хүүхэд ямар нэг байдлаар хөдөлмөр эрхэлдэг болохоо дурдсан бол 53 хүүхэд буюу 88 хувь нь хөдөлмөр эрхэлдэггүй гэжээ.

График 1. Өрхийн хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал



Хүүхдийн хөдөлмөрийг ил ба далд хэлбэрээр ашиглах явдаг байсаар байна. Хүүхдүүд өлсөхгүйн эрхээр, мөн өвчтэй эсвэл ажилгүй эцэг эх ам бүлээ тэжээхийн эрхээр биедээ ахадсан ажил хөдөлмөр эрхлэх нь буурахгүй байна. Аав нь хөгжлийн бэрхшээлтэй учир мал маллуулахаар хүүхдээ сургууль, боловсролоос хөндийрүүлсэн тохиолдол энэ судалгааны явцад таарсан. Ер нь хүүхдийг сурах насанд нь сургахгүйгээр ажил хөдөлмөр эрхлүүлэх нь архаг ядуурлыг бий болгох үндсэн шалтгаан юм. Хөдөөгийн малчин өрхөд хөвгүүд багаасаа мал аж ахуйн ажилд оролцдог нь тэдний боловсролын түвшин бүрэн дунд боловсролоор хязгаарлагдах хандлагыг үүсгэж байна.⁵

5 “Ядуурлын дүр төрх” тайлан, ҮСХ, 2018 он, 38 дахь тал

ТОХИОЛДОЛ 5

Сурагч Х хөдөөний малтай 6 хүүхэдтэй айлын том хүү. 9-р ангид ордог намар сургуульдаа ирсэнгүй. Ангийн багш сураг тавиад аавтайгаа мал дээр байгааг олж мэдсэн. Ээж нь дүү нартай нь сумын төвийн байшиндаа нүүж ирсэн байв. Багш 7 хоног хүлээгээд ирээгүй учир гэрт нь очив. Ээж нь их л уцаарлаж “энэ жил шинэ намаржаа авч ганц гэрээр байгаа учир аавдаа тусалж байгаа” гээд багшийн үгийг төдийлөн ойшоосонгүй. Багш 3 удаа очсон боловч амжилт олсонгүй. Хүүтэй уулзахаар малын бэлчээр дээр мотоциклоор очив. Хүү “ээж аав нь явуулахгүй байгаа, сургуульдаа явмаар байгаа- тухайгаа хэлэв. Багш хүүгийн мөрөөдлийн тухай ч бас ярилцав. Дараагийн айлчлалаараа багш хууль эрх зүйн хүрээнд шаардлага тавьж хүүгийн мөрөөдлийн тухай ч бас яриу. Хоёрдугаар улиралд хүү хичээлдээ ирж үргэлжлүүлэн сурч байгаа.

Хүүхэд харах тохиолдол. Нийгэм эдийн засгийн статус доогуур өрхөд амьдарч буй зарим хүүхдүүдийн хувьд дүү нараа харах гэрийн ажлын улмаас хичээл, ангийн үйл ажиллагаанаас байнга хоцрох, хичээлээ таслах тохиолдол гарч байна. Жишээ нь, эцэг эхээс авсан судалгааны явцад “айлын том хүүхэд тул дүү нараа харах гээд сургуулиас гарсан” гэсэн хариултууд нэлээдгүй ирж байв. Судалгааны явцад сургуульд нь буцаан оруулсан жишээтэй ч таарсан.

2.4 ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДЭД ХҮРТЭЭМЖ МУУ БАЙХ, ТОХИРОХ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН ДУТАГДАХ

Хөгжлийн бэрхшээлийг үйлдлийн бэрхшээлийн төрлөөр нь харааны, хэл ярианы, сонсголын, хөдөлгөөний, сэтгэц оюун ухааны, хавсарсан гэж ангилж үзэх нь бий. Судалгааны хүрээнд эдгээр бэрхшээлийн чухам аль нь хүүхэд суралцаж, боловсрол эзэмшихэд саад бэрхшээл учруулж байгааг тодорхойлсон. Хөгжлийн бэрхшээл тус бүрээр авч үзэхэд бэрхшээлийн тохиолдол болон суралцахад үзүүлж буй нөлөө нь харилцан адилгүй байгаа болно.

Хүснэгт 8. Хөгжлийн бэрхшээлийн тохиолдол ба асуудал

Харааны бэрхшээл	Тохиолдлын тоо(n)	Үндсэн бэрхшээл
1 Ойрын хараа муу	5	Суралцах орчин нөхцөл байхгүй, мэргэжлийн багш, сургалтын хэрэглэгдэхүүн байхгүй.
2 Холын хараа муу	-	
3 Нүдний хараа сул учраас шил зүүдэг	1	
4 Шил зүүдэг боловч хардаггүй	2	
5 Өнгө ялгагдаггүй	8	
Нийт	16	
Хэл, ярианы бэрхшээл	Тохиолдлын тоо(n)	Үндсэн бэрхшээл

1	Ээрдэг	6	Дохионы багш байхгүй. Суралцах орчин нөхцөл, сургах багш байхгүй.
2	Гацдаг	3	
3	Хэлгүй	2	
4	Дохионы хэлээр ярьдаг	1	
5	Харилцаа тогтоох чадвар муу	3	
6	Хавсарсан	1	
	Нийт	16	
	Сонсголын бэрхшээл	Тохиолдлын тоо(n)	Үндсэн бэрхшээл
1	Сул сонсдог	2	Дохионы багш, орчуулагч байхгүй. Суралцах орчин нөхцөл, сургах багш байхгүй. Зориулалтын хэрэглэгдэхүүн хангалтгүй.
2	Дүлий/огт сонсдоггүй	1	
3	Сонсголын аппарат зүүх шаардлагатай боловч боломжгүй	1	
4	Бусад	1	
	Нийт	5	
	Хөдөлгөөний бэрхшээл	Тохиолдлын тоо(n)	Үндсэн бэрхшээл
1	Саажилттай	7	Тэргэнцэртэй, анги ахих тусам том болж буй тул тэвэрч даахгүй болсон, гэр сургууль хооронд зөөх хүн болон дэд бүтэц, ариун цэврийн өрөө байхгүй.
2	Явж чаддаггүй	1	
3	Зогсож чаддаггүй	-	
4	Таягтай	1	
5	Тэргэнцэртэй	-	
6	Хэвтрийн	-	
7	Бусад	-	
	Нийт	9	
	Сэтгэц, оюун ухааны бэрхшээл	Тохиолдлын тоо(n)	Үндсэн бэрхшээл
1	Анхаарлын дутмагшил, хэт хөдөлгөөнтөх эмгэг	3	Ялангуяа аутизмын хүрээний эмгэгтэй ажиллах мэргэжлийн хүн байхгүй байна.
2	Тархины гэмтэл	5	
3	Аутизмын хүрээний эмгэг	1	
4	Дауны синдром	1	
5	Сэтгэл түгших, сэтгэц гутрал	1	
6	Бусад	1	
	Нийт	12	

ТОХИОЛДОЛ 6

Сургууль гэрийн хооронд явахад хамгийн хэцүү. Учир нь харааны бэрхшээлтэй учир зориулалтын зам байхгүй, үргэлж асран хамгаалагч нь хүргэж өгч авна. Хараа муу учраас байнга шил зүүдэг манай хүүхдийн хувьд ширээ хоорондын зай, самбар дээрх зүйл зэргийг хардаггүй. Самбар луу удаан ширтэхэд нүд ядардаг. Багш самбарт ойрхон суулгаж, ширээн дээр тусад нь материал бэлтгэж өгч хичээлээ заадаг.

ТОХИОЛДОЛ 7

Сургуульд суралцдаг гацдаг, муу ярьдаг хүүхдэд ангид нь дохионы орчуулагч байдаггүй. Гэрийхэнтэйгээ бага зэрэг ойлголцдог ч гадны хүмүүс болон үеийнхээ хүүхдүүдтэй холбоо үүсгэж чаддаггүй. Ямар нэг харилцан яриа үүсгэдэггүй. Дохионы багш байхгүй учир бусад хүүхэд, багш нар түүнтэй харьцах боломжгүй.

ТОХИОЛДОЛ 8

12 настай эрэгтэй хүүхэд эцэг эхийн хамт сумын төвд амьдардаг. Амьдралын боломж сайн. Тэрээр 5-р ангиасаа сургууль завсардсан. Учир нь сэтгэц, оюун ухааны бэрхшээлээс үүдэлтэй үе тэнгийнхний ялгаварлал. Тухайн хүүхдэд тохирсон тусгай хэрэгцээт боловсрол олгох бодлого хөтөлбөр хомсоос үүдэн боловсрол эзэмшиж чадаагүй. Ялангуяа аутизмын хүрээний эмгэгтэй хүүхэдтэй ажиллах мэргэжлийн хүн байхгүй байна.

Судалгаанд нэгээс дээш бэрхшээлүүд хавсарч илэрсэн тохиолдол харьцангуй цөөн тохиолдсон. Гэхдээ тухайн төрлийн бэрхшээл хавсарч илэрсэн тохиолдолд дараах асуудал, бэрхшээл сорилтууд тулгардаг байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хувьд ихэнх тохиолдолд сонсголгүй, хэл яриа нь ээрэх болон цус харвалтаас болж, хөл гарын хөдөлгөөн бэрхшээлтэй болох, саажилт хавсарсан байдлаар илэрдэг. Хөгжлийн бэрхшээлтэй өрхийн гишүүнээ асарснаар ажил эрхлэх боломжгүй болж тухайн өрх ядууралд өртөх эрсдэл улам нэмэгддэг байна.

ТОХИОЛДОЛ 9

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийнхээ талаар мэдээлэл маш муу, олон жил хэвтрийн байсан учир ой ухаан нь ямар байдгыг би мэдэхгүй. Хөгжлийн бэрхшээлтэй, байнгын асаргаанд байдаг хүүхэдтэй учир гэр бүлийн санхүүд хүнд байдаг. Гурил будаа, хувцас хунар, савангаас эхлээд эм тарианд зарцуулах мөнгөөр гачигдах тохиолдол цөөнгүй.

Нөгөөтээгүүр зарим эцэг эхчүүдийн хувьд хүн өвчнөөс шалтгаалан гэртээ байгаа хүүхдийнхээ талаар хэрхэн илэрхийлэхээ мэдэхгүй байв. Эдгээр тохиолдолд хүнд өвчнөөс шалтгаалан сургуульд суралцахад шаардлагатай санхүүгийн бэрхшээл өрх гэр, эцэг эхэд тулгардаг байна. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах, сургах багш байхгүй гэсэн хариулт нийтлэг байна.

Хүүхдийн сургуульд завсардсан буюу боловсролоос тусгаарлагдах үндсэн шалтгаан чухам юутай холбоотой байсан талаар тодруулахад дараах онцлог хүчин зүйлс байна. Судалгаанд хамрагдсан гурван хүүхэд тутмын нэг нь (33.3%) хөгжлийн бэрхшээл боловсролоос тусгаарлагдах үндсэн шалтгаан болж байгааг дурджээ. Үүний зэрэгцээ өрхийн байршил болон амьжиргааны нөхцөл нөлөөлдөг болохыг нийт хүүхдийн 15.0 хувь нь тэмдэглэжээ. Мөн БСШУЯ-ын сайдын 2019 оны А/292 дугаар тушаалаар “хөгжлийн бэрхшээлтэй

хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамран сургах” журмыг баталж, хэрэгжүүлэх зөвлөмжийг ЕБС-д хүргүүлсэн байдаг. Харамсалтай нь уг судалгааны мэдээлэл цуглуулах явцад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуульд тэгш хамруулах нөхцөл байдал өмнөхөөсөө мэдэгдэхүйц дээрдээгүй байсан юм.

2.5 ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛ

Судалгаанд оролцсон хүүхдүүдийн 6.7 хувь нь жендэрт суурилсан хүчирхийллээс хамаарч боловсролоос хөндийрч, сургуулиас завсардсан гэж үзсэн байна.

Жендэрт суурилсан хүчирхийлэл гэдэг нь жендэрээс үүдэлтэйгээр бусдад бие мах бодийн, бэлгийн, сэтгэл санааны гэм хор, эдийн хохирол учруулсан, учруулж болзошгүй үйлдэл, эс үйлдэхгүйг хэлдэг. Энэхүү чанарын судалгааны хүрээнд маргиналчлагдсан бүлгийн хүүхэд боловсролоос тусгаарлагдахад хүргэж буй жендэрт суурилсан хүчирхийллийн хэд хэдэн тохиолдлыг жишээ болгон авч үзсэн болно.

Бэлгийн халдлага, дарамтад өртсөн тохиолдол. Ийм нөхцөл байдал, ялангуяа хүүхдийг сургуулиас хөндийрч тусгаарлагдахад шууд нөлөөлсөн байна. Бэлгийн хүчирхийлэлд өртсөн, хүчингийн гэмт хэргийн хохирогч болж байсныг ангийхан, үе тэнгийнхэн нь мэдсэн учраас сургуулийн хүүхдүүд “биеэ үнэлэгч” гэж шоолох, доромжлох нь тухайн хүүхдийг сургуулиа орхих хангалттай шалтгаан болдог ажээ. Энэ нь уламжлалт хохирогчийг буруутгах хандлага соёл түгээмэл байгаагийн илрэл бөгөөд нөгөө талаас хүүхэд хамгааллын байгууллагуудын үйл ажиллагаа уялдаа холбоо тааруу, хүүхдийн эрхэд ээлтэй биш, багш, нийгмийн ажилтнуудын хувь хүний нууцыг хадгалах, хамгаалах талын хүний эрхийн мэдлэг, мэдрэмж сул байгаагийн илрэл юм.

Хүүхэд төрүүлсэн тохиолдол. Жирэмсэн учраас өрхийн эмч байнга анхаардаг болж түүнийг нь ангийн багш нь мэдээд хандлага нь өөрчлөгдөж ямагт сөргөөр харах, гадуурхах тохиолдол гарч байжээ. Түүнчлэн нутгийн хүмүүсийн хэл ам, хохирогчийг буруутгах хандлага зэрэг гадна өсвөр насандаа ээж болсон охины хувьд ангийнхнаасаа ичиж сурах сонирхолгүй болох шалтгаан болжээ. Мөн нялх хүүхэдтэй тул орхих боломжгүй зэргээс болж сургуулиас гарсан тохиолдол судлаачидтай таарсан. Энэ нь жендэрт суурилсан хүчирхийлэл сургууль завсардах томоохон хүчин зүйл болдгийн жишээ юм.

Ялгаварлан гадуурхалт, үе тэнгийнхний дарамт шахалтад өртөж байсан тохиолдол. Судалгаанд хамрагдсан хүүхдүүд анги хамт олон, сургуулийн бусад хүүхдүүд болон багш нарын зүгээс ялгаварлан гадуурхалтад өртөж байснаа дурджээ. Жишээ нь, дээд ангийн хүүхдүүдээс дээрэлхэх, дарамтлах тохиолдол цөөнгүй гардаг хэмээн дурдсан. Мөн биеийн гадна төрх, хөгжлийн бэрхшээл болон хүүхэд өөрөө гэмт хэрэгт холбогдсоноос болж үе тэнгийнхэндээ гадуурхагдсан тохиолдол байна. Мөн асрамжийн газарт амьдардаг учир сургуулийн орчинд ялгаварлан гадуурхалт их өртдөг. Сургуулийн дүрэмт хувцас, ном сурах бичгийн асуудал их хүнд байдаг, анги засварын мөнгө нэхэх үед хамгийн хэцүү байдаг хэмээсэн байна. Ийм төрлийн

хүчирхийлэлд өртөж байсан хүүхдүүд сэтгэл санааны байнгын хямралд ордог байна. Ялгаварлан гадуурхалтад өртөх үндсэн шалтгаан нь хувцас хунар, эд материалын хомс, дорой байдал, биеийн гадаад үзэмж, амьдардаг газрын байршил (алслагдсан газар, захын гэр хороолол зэрэг), эцэг эхийн архины хамаарал, гэмт хэрэгт холбогдож байсан талаарх мэдээлэл зэрэг нь нөлөөлдөг гэжээ. Ер нь ямар нэгэн хэлбэрийн хүчирхийлэл, үе тэнгийнхний дарамт шахалтад өртсөн хүүхэд суралцаж байсан сургуульдаа үргэлжлүүлж сурах сонирхолгүй болдог аж.

2.6 БАГШИЙН ТОО, ЧАНАР, ЗААХ АРГА ЗҮЙ

Судалгаанд хамрагдсан хүүхдүүд анги хамт олон, сургуулийн бусад хүүхдүүд болон багш нарын зүгээс ялгаварлан гадуурхалтад өртөж байснаа дурджээ. Багш, сургуулийн нийгмийн ажилтан, эмч нарыг сурагчдын хувийн амьдралтай холбоотой нууц хадгалж чаддаггүй, хүүхдүүдийг анги хамт олон болон бусдын өмнө эвгүй байдалд оруулдаг гэжээ. Жишээ нь, ангийн багш нь муу хувцастай бас хичээл номондоо сайн биш гэж байнга дарамталдаг, загнадаг учир сургуульдаа явах дургүй гэсэн хариулт нилээдгүй ирж байлаа. “Ангийн багш муу хувцастай бас хичээл номондоо сайн биш гэж байнга дарамталдаг” гэж судалгаанд оролцогч хүүхэд хэлсэн. Хэдийгээр санхүүгийн боломж бололцоо хүүхдийг сургуульдаа явахад, суралцахад нөлөөлөх хүчин зүйл мөн боловч хүүхэд суралцах хүсэл сонирхолгүй болох буюу сургуулиа орхиход багшийн хандлага чухал нөлөөтэй ажээ.

ТОХИОЛДОЛ 10

Манай ангид 9р ангидаа хүүхэд төрүүлсэн хүүхэд байдаг. Ангийхан гадуурхаж, шоолох нь гайгүй боловч багш нарын хандлага сөрөг байдаг.

ТОХИОЛДОЛ 11

15 настай эмэгтэй. Багш нь юу ч сурахгүй байна гээд сургуулиас гаргасан. Одоо аавыгаа асраад гэртээ байдаг.

2016 онд УИХ-аар баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай” хуулийн 16.2-р зүйлд “Бүх шатны боловсрол олгох сургалтын байгууллагын багш, нийгмийн ажилтан ХБХ-тэй ажиллах мэдлэг арга зүйг эзэмшсэн байна” гэж ЕБС-ийн багш нарт байвал зохих ур чадварын талаар тусгасан боловч тухайн хуулийн заалт болон сургууль дээрх багш нарын бодит үйл ажиллагаа ихээхэн зөрүүтэй, багш нар ХБХ-тэй ажиллахад бэлэн биш байна.

2.7 ХЭЛ/ ҮНДЭС УГСААНД СУУРИЛСАН ГАДУУРХАЛ

Үндэстний цөөнхийн хувьд казах болон тува хүүхдүүдийн нөхцөл байдлыг авч үзсэн болно. Казах, тува хүүхдүүдийн хувьд хэл, соёл, сурах бичиг зэрэг нь дутагдаж буй хэрэгцээт үндсэн зүйлс болж байна. Тухайн хүүхдүүдийн суралцах, боловсрол эзэмшихэд тулгарч буй бэрхшээл, тулгарч буй сорилтыг

авч үзэхэд өмнөх бүлэгт дурдсан шалтгаан, нөхцөлийн зэрэгцээ хэл, соёлоос үүдэлтэй дараах зүйлс нийтлэг байна. Үүнд:

- 1-р ангид монгол хэл огт мэдэхгүй хүүхдүүд орж ирдэг. 1-р ангийн сурах бичиг тува хэлээр орчуулагдсан байдаг. 2-с дээш ангийнх байхгүй учир монгол хэлээр ойлгоход хэцүү байдаг. Сургуулийн орчин казак хүүхдүүд ихтэй учир ойлголцож, найзалж нөхөрлөж чаддаггүй.
- Тува хэлний ном гарын авлага, ТВ нэвтрүүлэг байхгүй учир эх хэлээ мартаж эрсдэл их. Баян-Өлгийн Цэнгэл сумын хувьд хүн амын тал нь казак үндэстэн учир нийгмийн харилцаанд орохдоо казак хэлийг сурах шаардлага тулгардаг.
- Үндэстний цөөнхийн (казак, тува) онцлог харуулсан ямар нэг соёлын арга хэмжээ, тусгай анги танхим байхгүй.
- Сурагчид хэлний бэрхшээлээс болж сургалтын стандартаа хангаж чаддаггүй.
- Хэл соёлын хувьд эцэг эх нь дэмждэг боловч сургууль болон төрөөс ямар ч дэмжлэг байхгүй. 2013 оны хос хэлний хөтөлбөрийг шинэчлэх хэрэгтэй байна.
- Казак хүүхдийн хувьд гадаадаас ирээд Налайх дүүрэгт сургуульд орох гэсэн боловч монгол хэл мэдэхгүйгээс болоод сурч чадаагүй. Насан туршийн боловсролын төвд дүйцсэн хөтөлбөрөөр суралцаж байгаа.
- Тува, казак хүүхдүүдийн хоорондын зөрчилдөөний асуудал их байдаг.

Үндэстний цөөнхийн хувьд хэл соёлын бэрхшээл дээр нэмээд хөгжлийн бэрхшээлтэй байх, нийгэм эдийн засгийн статус доогуур өрхийн хүүхэд байх нь нийгмээс тусгаарлагдах, эмзэг эрсдэлт нөхцөлд орох үндэс болж байна. Хэлний бэрхшээлтэй улмаас өөрийгөө бүрэн илэрхийлж чадахгүй байх, ялгаварлан гадуурхагдах, мэдээлэл авч чадахгүй байх зэрэг эрхийн зөрчлийг үүсгэж улмаар сургуулиас завсардах нөхцөл болж байна.

2.8 БОЛОВСРОЛТОЙ ХОЛБООТой ТӨЛБӨР ХУРААМЖ

Юуны өмнө өрхийн амьжиргаа, орлогын түвшинтэй холбоотой ядуурал нь хүүхэд боловсрол эзэмших боломжийг хязгаарладаг байна. Тухайлбал, өрхүүд боловсролын зардал, эсвэл боловсролтой холбоотой төлбөр хураамж зэрэг зардлыг төлж дийлэхгүй байгаа нь хүүхдийн үнэ төлбөргүй, чанартай боловсрол эзэмших боломжийг хааж байна. Энд бид өрхийн байршил, орчин нөхцөл, амьжиргаа, орлогын түвшин зэргээс хамаарч хүүхдийн суралцах, боловсролоос тусгаарлагдах үйл явцад нөлөөлж буй хүчин зүйлсийг авч үзсэн.

Сургуулиас төлбөр хураамж шаарддаг тохиолдол. Сургуулиас элдэв төлбөр хураамж шаардах нь хүүхдийг сургуулиас завсардахад нөлөөлдөг үндсэн биш боловч нэгээхэн хүчин зүйл хэвээр байна. Санхүүгийн боломжгүй нөхцөлд амьдарч буй хүүхдүүдэд анги цэвэрлэгээ, анги засвар, хуримтлал зэрэг төлбөрийг шаардах, ангийн бусад хүүхдийн дэргэд нэхэх нь ангийнхаа хүүхдүүдээс ичих, санаа зовох, улмаар хичээлдээ явах дур сонирхлыг бууруулдаг байна. Ихэнх эцэг, эхчүүдийн хувьд хүүхдээ бусдаас дутаахгүйн тулд шаардсан

төлбөр хураамжийг аль болох төлөхийг хичээдэг боловч санхүүгийн боломжгүй зарим өрхийн хүүхдүүдэд эдгээр төлбөр хураамж хүндээр тусдаг байна.

- Олон төрлийн мөнгө хурааж байгаа нь санхүүгийн дарамт үүсгэдэг.
- Ангийн хуримтлал болон засварын мөнгө, уралдаан тэмцээний хураамж маш их дарамт болдог.
- Мөнгөө өгөхгүй тохиолдолд багш, ангийн хүүхдүүдийн дэргэд нэхэх нь дарамттай байсан.
- Зөвхөн эмээгийн тэтгэврээр амьдардаг учир санхүүгийн дутагдалд ордог.
- Сургууль анги танхимын засвар энэ тэр хураамж авдаг. Өгөхгүй болохоор багш нар нь дургүй.
- Нэг өрхөөс 2-3 хүүхэд сургуульд зэрэг сурдаг болохоор дүрэмт хувцасны асуудал хүнд тусдаг, уван цувуулаад боломжоороо авч өгдөг. Гэхдээ дүрэмт хувцас хүрэлцэхгүй (ах, эгчийнхээ эсвэл дүүгийнхээ хувцсыг ээлжилж өмсдөг) тохиолдолд дүрэмт хувцасгүй сургууль дээр очсоноор багш, сургуулийн удирдлагад загнуулах, бусдын өмнө эвгүй байдалд орохоос эмээж, дүрэмт хувцасгүй үедээ хичээлдээ очдоггүй гэжээ.

Сурах бичгийн зардал байхгүй тохиолдол. Ихэнх тохиолдолд өрхийн амьжиргаатай холбоотой гардаг бэрхшээл. Номын хүртээмж хүрэлцээ тааруу тул, ангиас нь ном өгдөггүй. Үүний улмаас хичээл, сургалтаас хоцордог байна.

ТОХИОЛДОЛ 12

Өрх толгойлсон эцэг эхчүүд хүүхдийн сурах бичгийг сургуулиас түрээсээр авдаг, заримыг нь худалдаж авдаг. Сургууль тарсны дараа түрээсийн номнуудыг буцааж өгдөг. МСҮТ-д сурдаг хүүхдийн хувьд, хичээлийн туслах хэрэглэгдэхүүн материал, хичээлийн жигдрэлийн хувцас гэх мэт зүйлсийг өөрөө худалдаж авдаг тул, хүндрэлтэй байдаг байна. COVID-19-ийн үед ЕБС-ийн зүгээс бүх номыг хурааж авсан. Учир нь нэг номны үнэ 200-500 төгрөгөөр түрээсэлдэг учраас гэртээ авч ирэхийг зөвшөөрөөгүй. Тиймээс номтой хүүхэд дээр очиж хичээлээ хийх зэргээр аргацааж байна.

2.9 ШИЛЖИН СУУРЬШИГЧДЫН ТАЛААРХ ҮР ДҮНТЭЙ ЗОХИЦУУЛАЛТ СУЛ

Шилжин ирсэн, бүртгэлгүй тохиолдол. Монгол Улсын дотоод шилжих хөдөлгөөний талаар судалгаанд дурдсанаар шилжих хөдөлгөөний үр дүнд шилжин явагчдын ажлын байр, боловсрол, хүүхдүүдийн сургалт, гэр бүлийн болон найз нөхдийн харилцаа, орон сууцны нөхцөл, нийтийн тээврийн хэрэгсэл, зах зээлд оролцох боломж, орчин ахуй, орлого, эрүүл мэнд сайжирсан гэж дүгнэжээ. Гэвч шилжих хөдөлгөөн нь зарим өрхөд ашигтай, зарим өрхөд хохиролтой байна. Ялангуяа шилжих хөдөлгөөнөөс ашиг хүртэж чадаагүй, амьжиргаа тааруу өрхөд амьдарч буй хүүхдэд тааламжтай нөлөө үзүүлээгүй, үр дагавар нь илүү ноцтой юм. Хотод шилжин суурьшсан өрхийн хүүхдүүд ядуурал, оршин суух бүртгэлгүйн улмаас сургуульд явахгүй байгаа нь

бусад судалгаанаас⁶ харагдаж байна. Энэхүү судалгаанд хамрагдсан хүүхдийн хариултаас үзэхэд шилжин суурьших үйл явцтай холбоотой суралцах бэрхшээл цөөнгүй тохиолдож байна. Тухайлбал, хүүхдээ ЕБС-иас МСҮТ-рүү шилжсэн, аав, ээж нь өөр газраас шилжин ирсэн тохиолдолд хүүхэд сургуулиас хөндийрсөн гэжээ. Ингэснээр дараах зүйлс хүүхдэд тохиолдож байна.

Дутагдаж буй хэрэгцээт зүйлс	Тулгарч буй сорилт, бэрхшээл
Орлого, мөнгө санхүү	Анги хамт олны дунд ганцаардах
Хичээлийн хэрэглэгдэхүүн	Хүүхдүүдийн харилцаа, хандлага
	Үе тэнгийнхний зүгээс гадуурхалд өртөх

Бичиг баримтгүй тохиолдол. Эцэг эх нь гэр бүлийн баталгаа байхгүй, гэр бүл салсны улмаас хүүхдийнхээ бичиг баримтыг өгөхгүй байгаагаас үүдэн сургуульд суралцаагүй тохиолдлууд гарсан. Бичиг баримтгүй байх нь эцэг эхчүүд тогтвортой ажил эрхлэх боломжийг хааж, хүүхдийн сурч боловсрох эрхэд бэрхшээл учирдаг байна. Судалгаанаас үзэхэд шилжин ирсэн, бүртгэлгүй, мөн бичиг баримтгүй байх зэрэг нь хүүхдийн сурч боловсроход дам байдлаар нөлөөлж байна. Хүснэгтэд хүүхдийн сурч боловсроход шилжих хөдөлгөөн, бүртгэл хэрхэн нөлөөлж буй зүй тогтлыг эцэг эх, асран хамгаалагчтай хийсэн ярилцлага, хүүхдийн кейс судалгаанд тулгуурлан харуулсан юм.

Хүүхдийн сурч боловсроход шилжих хөдөлгөөн, бүртгэл хэрхэн нөлөөлж буйг судалгаанд оролцогчдын мэдээлэл дээр үндэслэн дараах байдлаар харууллаа.



6 Монгол улс: Хүн амын дотоод шилжих хөдөлгөөний судалгаа, ОУШХБ, 2018 он, 23 дахь тал

Нөгөөтээгүүр хөдөө орон нутгаас шилжин ирсэн иргэд тогтсон хаяг, орон байр тодорхойгүй, ах дүү хамаатан садан найз нөхдийнхөө хашаанд буух нь нийтлэг тохиолддог. Хороо, дүүрэг шилжин ирэгсдийг хүлээн авдаггүй. Бүртгэлгүй болохоор хүүхдээ цэцэрлэг, сургуульд хамруулж чаддаггүй. Байгаа айлынхаа хаягаар хүүхдээ цэцэрлэг сургуульд оруулдаг. Мөн ямар ч халамжийн үйлчилгээг авч чаддаггүй. Энэ асуудал ганцхан хөдөө орон нутгаас шилжин ирсэн иргэдээс гадна хот дотор нэг дүүргээс өөр дүүрэгт шилжин очиход харьяаллын сургуулийн хүүхдийн тоо хэт их, анги танхим хүрэлцээ багатай зэргээс шалтгаалан хүүхэд хуучин сургуульдаа холоос явах нь ажиглагдаж байлаа.

2.10 ДЭД БҮТЭЦ, ТОО, ЧАНАР

Нийслэлийн зарим дүүргүүдийн хувьд хорооны нутаг дэвсгэр дээр сургууль байхгүйн улмаас хүүхдүүд өөр сургуульд хамрагдах үйл явц нэмэгдэж байна. Хүүхдийн сургууль хол учир өглөө эрт гарч, орой оройтож харина, автобус хүлээнэ, түгжирнэ, гэр хороололд болохоор гудамж харанхуй, тэнэмэл ноход дайрах, дээрэмдүүлэх, ямар нэгэн хүчирхийлэлд өртөх эрсдэл хамгийн өндөр байдаг. Эцэг эх болон ах эгч нар нь ээлжлэн буудал дээр тосно. Энэ нь нийгэм-эдийн засгийн эмзэг байдалтай нийлбэл, тухайлбал олон хүүхэдтэй айл өрхүүдийн хувьд сурагчийн дүрэмт хувцас, хоол унааны мөнгө гэх мэт бүх зүйл хүндрэлтэй болдог байна.

Унааны мөнгөтэй холбоотой тохиолдол. Нийслэлийн захын дүүргүүдийг бодвол хөдөө орон нутагт суралцахад унааны зардал шаардагддаггүй. Учир нь аймаг, сумдад гэр сургуулийн хооронд ихэвчлэн алхаж очдог. Харин нийслэлийн захын дүүргүүдийн хувьд нөхцөл байдал харьцангуй өөр юм. Хотын шилжигч өрхүүдийг шилжигч бус өрхтэй харьцуулахад хамгийн ойрын дунд сургуулиас нэлээд хол зайд суурьшсан байгаа нь тэд ихэвчлэн хотын захаар суурьшсаныг илтгэнэ. Тухайлбал, шилжигч бус өрхүүд сургуулиас дунджаар 1.1 км хол газарт байдаг бол шилжигч өрхүүд 6.8 км хол зайнд суурьшсан байна. Хотод шилжин суурьшсан өрхийн хүүхдүүд ядуурал, оршин суух бүртгэлгүйн улмаас сургуульд явахгүй байна.

Улаанбаатар хотын захын дүүрэгт суралцаж буй хүүхдүүдийн хувьд унааны мөнгөгүй үедээ алхах, зарим тохиолдолд унааны мөнгөө хэмнэж, үүгээрээ хоолны мөнгөө аргацаах тохиолдол байдгаа илэрхийлсэн байна.

ТОХИОЛДОЛ 13

Автобусны мөнгө гэрийнхнээсээ авдаг заримдаа эцэг эх өгч чадахгүй тохиолдол гарна. Зарим тохиолдолд унааны мөнгөнөөсөө хэмнэж, хоолны мөнгө хийдэг. Ихэнхдээ сургууль дээрээ ходоод хоосон байдаг. Хоолны мөнгө байхгүй үе олон. Гэртээ сайн хооллоод, сургууль дээрээ юм идэхгүй, 8-аас дээш цаг байх тохиолдол байдаг.

ГУРАВ. МАРГИНАЛЧЛАГДСАН БҮЛГИЙН ХҮҮХДИЙГ БОЛОВСРОЛД ХАМРУУЛАХ БОДЛОГЫН АСУУДЛУУД

Боловсрол нь өөрөө хүний эрх төдийгүй бусад эрх, эрх чөлөөгөө эдлэх хамгийн чухал эх сурвалж юм. Боловсрол нь чадавхийн эрх болохын хувьд нийгэм, эдийн засгийн хувьд хязгаарлагдмал хүүхдүүд, томчууд ядуурлаас өөрсдийгөө гаргах, нийгмийн амьдралд бүрэн төгс оролцох арга замаа олох үндсэн хэрэгсэл болдог. Боловсрол нь эмэгтэйчүүдийг чадавхжуулах, хүнд, хортой хөдөлмөр, бэлгийн мөлжлөг өртөхөөс хүүхдүүдийг хамгаалах болон хүний эрх, ардчиллыг хөхүүлэн дэмжих, хүрээлэн буй орчноо хамгаалах, хүн амын өсөлтийг хянах зэрэгт нэн чухал үүрэгтэй. Төрийн санхүүгийн хөрөнгө оруулалтаас хийж болох хамгийн сайн хөрөнгө оруулалт бол боловсрол хэмээн хүлээн зөвшөөрөгддөг. Боловсролын ач холбогдол нь зөвхөн практик зүйл биш юм. Чөлөөтэй, өргөн хүрээтэй сэтгэх чадвар бүхий сайн боловсрол эзэмшсэн, идэвхтэй хувь хүн л хүн болж төрсний гавьяа, аз жаргалыг мэдэрдэг. Тиймээс ч олон жилийн турш боловсролын салбар Засгийн Газрын бодлогын тэргүүлэх чиглэл байсаар ирсэн, одоо ч хэвээр байна. Судалгаанд хамрагдсан талбаруудыг авч үзэхэд ЕБС-ийн сургуулийн насны бүх хүүхэд сургуульд бүртгэлтэй боловч амьжиргааны түвшин, хөгжлийн бэрхшээл, шилжих хөдөлгөөн бүртгэл, газарзүйн байршил, эцэг эхийн хандлага, хариуцлага зэрэг тодорхой шалтгааны улмаас сургууль завсардсан байна.

2018 онд БСШУС-ын сайдын тушаалаар “Бага, суурь бүрэн дунд боловсролын дүйцсэн хөтөлбөрөөр сургалт зохион байгуулах журам” батлан гаргасан нь маргиналчлагдсан бүлгийн хүүхдийн эрх, сурч боловсрох эрхийг хангах эрх зүйн орчинд дэвшил гарсан. Уг журмаар сургуульд огт суугаагүй, 2 ба түүнээс дээш жил завсардсан хүүхэд, залууст суурь боловсрол заавал олгох, бүх нийтийн ерөнхий боловсролыг үнэ төлбөргүй нөхөн эзэмших боломж олгож байна. Дээрх сургалт нь маргиналчлагдсан бүлгийн хүүхдүүдийн боловсрол эзэмших хэрэгцээ, боломж, хувийн болон хөгжлийн онцлогт нийцсэн, олон хувилбартай, уян хатан байхаар зохицуулсан нь туйлын чухал. Зөвхөн танхимын бус явуулын багш, холимог бүлэг, зайны, гэрийн буюу шавь сургалтын, түр цугларалт, бие даах зэрэг хэлбэрээр зохион байгуулахыг орон нутгийн засаг захиргаанд үүрэг болгожээ.

Сургалтын үйл ажиллагааг нэг хүүхдэд ногдох хувьсах зардлаар санхүүжүүлж байгаа ч, тэдгээр хүүхдүүдийг үдийн цай/хоолны хөтөлбөрт хамруулахгүй байгаа нь бодлогын хувьд учир дутагдалтай юм. 2020 оны 9 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд мөн л дүйцсэн хөтөлбөрөөр суралцагчид орхигдсон байна.

Маргиналчлагдсан бүлгийн хүүхдүүдийг боловсролд тэгш хамруулах асуудалд зөвхөн боловсрол, сургалтын чиглэлээр авах арга хэмжээ хангалтгүй бөгөөд эрүүл мэнд, хоол тэжээл, хүүхэд хамгаалал, нийгмийн халамжийн ажил үйлчилгээнд цогцоор хамруулж байж шийдэгдэх салбар хоорондын асуудал гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстой.

Сүүлийн үед бүх хүүхдийг сургуулийн өмнөх болон бага дунд боловсролд бүрэн хамруулах, нийгмийн ялгаатай бүлгүүдийг боловсролд тэгш хамруулах чиглэлд бодлого хандах болсон нь зүй ёсны юм. Тэгш хамруулах боловсролын үндсэн үзэл санаа нь нийгэм дэх ялгаварлан гадуурхалтын (discrimination) эсрэг чиглэх бөгөөд маргиналчлал (marginalization) буюу хавчигдан, шахагдахын эсрэг чиглэдэг бөгөөд хүмүүсийн хэл/ соёл, бэлгийн чиг баримжаа, бие эрхтэн, оюун ухааны чадвар алдалт болон бусдаас ялгагдах онцлог зэргийг хэвийн үзэгдэл гэж үздэг.

Монгол Улсын төр үндэсний болон олон улсын өмнө хүлээсэн үүргийн дагуу боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, тэгш хамруулах боловсролыг хэрэгжүүлэхэд чиглэсэн шат дараалсан арга хэмжээг 2003 оноос хойш тасралтгүй авч хэрэгжүүлж байгаа билээ. Гэсэн хэдий ч 2018 онд хэрэгжүүлсэн Японы Хүүхдийг ивээх сан (ЯХИС)-ийн “Монгол Улсын хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь” төслийн хэрэгцээ тодорхойлох судалгааны үр дүнгээс үзэхэд тэгш хамруулах боловсролыг зөвхөн “Бие махбодын бэрхшээлтэй, эмгэг согогтой хүүхдийг ердийн сургуульд хамруулах” гэдэг хязгаарлагдмал ойлголттой, тэгш хамруулах боловсролын үзэл санаа, зарчмыг бүрэн дүүрэн хүлээн зөвшөөрөөгүй, бэлэн биш байгаа нь нотлогдож байна. Энэ нь Монгол улсад тэгш хамруулах боловсрол гэж юуг хэлэх тухай бодлогын баримт бичиг боловсруулагдаж гараагүй, энэ чиглэлд авах алхмууд төлөвлөгдөөгүй байгаатай холбоотой юм.

3.1 НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН СТАТУС ДООГУУР/ ЭМЗЭГ БҮЛГИЙН ХҮҮХДИЙН БОЛОВСРОЛ ЭЗЭМШИХЭД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

Монгол Улсын хэмжээнд авч үзэхэд улсын сургуулиуд төлбөргүй боловч хүүхдээ сургуульд явуулахад нэмэлт зардал шаардагддаг болохыг бодлогын баримт бичигт дурджээ. Сургуульд явуулахад шаардагддаг нэмэлт зардлыг авч үзэхэд сургуулийн засвар үйлчилгээ, анги танхимын ширээ сандал, тоног төхөөрөмжийг шинэчлэхтэй холбоотой зардал, хичээлийн сурах бичиг, дүрэмт хувцас авах зэрэг зардлууд багтдаг байна. Боловсролын тухай хуулинд төлбөр хураамж авахыг хориглосон боловч, холбогдох яамны сайдын 2019 оны А/508 тоот Гэрээний үлгэрчилсэн загвар батлах тухай тушаалын 2.12-д Хүүхдийнхээ суралцаж буй анги танхимын эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах, орчин нөхцөлийг сайжруулах засвар үйлчилгээнд зориулан хичээлийн жилд нэг удаа хандив, дэмжлэг үзүүлэх зүйл заалтыг баталсан ба үүнд үндэслэн анги засварын мөнгийг эцэг эхчүүдээс хандив, хураамж нэрээр авсаар байгаа юм. Эцэг эхийн хурлаар тухайн гэрээг тайлбарлаж өгдөггүйн улмаас сургууль бүрд харилцан

адилгүй тогтоож, эцэг эхчүүдээс нэхэх тохиолдол байгаа нь төлбөр хураамжийг төлөх боломжгүй эмзэг бүлгийн өрхийн хүүхдэд хүндээр тусч байна.

Нийгэм эдийн засгийн статус доогуур, амьжиргааны түвшин тааруу өрхүүд хүүхдийнхээ наад захын хэрэгцээг хангаж чадахгүй, тухайлбал хоол хүнс, хувцас, байр, унааны болон бусад зардлыг төлж чадахгүй байгаагаас хүүхдээ сургуулиас завсардуулах тохиолдол гарч байна. Мөн ядуу өрхийн хүүхдүүд сургуулийн дүрэмт хувцас болон өмсөх хувцас муугаас шалтгаалж, үеийн хүүхдүүдээс ичих, улмаар хичээлд явахаас цааргалж, сургуулиас завсардах, хөндийрөх явдал хааяагүй тохиолдож байна.

Өрхийн орлогод хувь нэмэр оруулахаар хүүхдийн ажил хөдөлмөр эрхлэх нь хичээлдээ тогтмол суухад саад болоод зогсохгүй гэрийн даалгавар хийх цаггүй болж, улмаар сурлагын амжилтад сөргөөр нөлөөлж эхэлдэг.

Шилжин суурьшигчдын хүүхдийн боловсролын асуудал

Улсын хэмжээнд бага боловсролын хамран сургалтын цэвэр жин буурсан үзүүлэлттэй байгаа нь нийслэл Улаанбаатарт энэ үзүүлэлт ихээхэн буурсантай холбоотой юм. Нийслэлд жил бүр олон мянган иргэн хөдөөнөөс шилжин ирж, үүний улмаас хотын захын сургуулиудын ачаалал ихсэж, зарим сургууль гурван ээлжээр хичээллэх болсноор хүүхэд сургуульд бүрэн хамрагдах бололцоо нөхцөл муудсан, хотын ядуу өрхөд амьдарч буй хүүхдүүдийн хувьд сургуульд сурах амьдралын боломж тааруу, зарим нь ажил хөдөлмөр эрхэлж, сургууль завсардах явдал гарч байгаатай энэ нь холбоотой. Нийслэлийн Баянзүрх дүүргийн 28 хорооноос гэр хороолол бүхий 4 хороо (9, 21, 23, 24-р хороо)-дын нийт өрхийн дунд сургууль завсардсан хүүхэд, насанд хүрэгч, бичиг үсэг үл мэдэгч иргэдийг илрүүлэх судалгааг Насан туршийн боловсролын төвөөс 11466 өрхөд хийжээ. Сургуулийн насны боловч сургуульд хамрагдаагүй 96 хүүхэд байсны 24 (25%) нь сургуульд огт элсэн ороогүй, 64 (66,7%) нь сургууль завсардсан байв. Ялангуяа хөдөө орон нутгаас шилжин ирэгсдийн дотор хувцас хунар тааруу, амьдралын боломж муутайн улмаас үе тэнгийнхэн төдийгүй багш нар, сургуулийн удирдлагад гадуурхагдаж, сэтгэл санааны дарамтад орсноос сургууль завсардах бас нэг шалтгаан болж байна гэж судлаачид үзжээ.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2017 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн А/17 дугаар захирамжаар хөдөө орон нутгаас Улаанбаатар хотод байнга оршин суухаар ирэх иргэдийн шилжилт хөдөлгөөнийг 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэл түр хугацаанд зогсоосон шийдвэр гаргаж байсан бөгөөд 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл хугацааг сунгах шийдвэр гаргасан байна. Энэ хориг нь нийслэл рүү шилжин ирэх хөдөлгөөнийг бууруулахад хүргэсэн ч албан ёсны статистик бүртгэлд бүртгүүлээгүй шилжигчдийн тоог нэмэгдүүлэхэд хүргэж байна.

Хэдийгээр Монгол Улсын хуулиар хүн ам шилжин ирсэн газраа хаягийн хөдөлгөөнөө шинэчлүүлж заавал бүртгүүлэх ёстой боловч Улаанбаатар хотод шилжин ирэгч өрхүүдийн бараг тал хувь бүртгүүлээгүй байна. Бүртгэл нь нийгмийн суурь болоод халамжийн үйлчилгээ хүртэхэд зайлшгүй чухал бөгөөд

ажилд орох, засаг захиргааны түвшинд хууль ёсны эрхээ эдлэх зэрэгт ихээхэн ач холбогдолтой билээ.

Мөн түүнчлэн Боловсролын тухай хуульд суурь боловсрол эзэмшүүлэх сургалтад харьяа айл өрхийн хүүхдийг хамруулах үүргийг баг, хорооны засаг даргад, Бага дунд боловсролын тухай хуулиар сургуулийн захирал хамран сургах тойргийн хүүхдийг сургуульд бүрэн хамруулж, тэдэнд суурь боловсрол заавал эзэмшүүлэх үүрэгтэй аль аль нь хариуцахаар заасан нь эцэстээ хэн нь ч хариуцлага хүлээхгүй байгаа нөхцөл байдалд хүргэж байна.

3.2. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН БОЛОВСРОЛЫН АСУУДАЛ

Экспертийн ярилцлага болон судлаачдын ажиглалтаас үзэхэд хот, хөдөөгийн аль алинд нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд энгийн сургуульд хамрагдах боломж, хүртээмж тааруу байна. Юуны өмнө зориулалтын тоног төхөөрөмж, сургалтын материаллаг орчин, тусгай хэрэгцээт боловсрол олгоход чиглэсэн багш мэргэжилтэн байхгүйн зэрэгцээ багш, ажилчдын зүгээс хүүхэдтэй харилцах хандлага, ур чадвар дутагдалтай байгааг дурдсан байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ердийн сургуульд тэгш хамруулан сургах асуудал “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль”-д нэг бүлэг¹ болон орсон байдаг ч хангалттай, иж бүрэн зохицуулалтгүй байна.

Иргэнийг сурч боловсроход үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, хөгжлийн онцлог, эрүүл мэнд, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхахгүй байх, эх хэлээрээ сурч боловсрох тэгш боломж, нөхцөлөөр хангах тухай Боловсролын тухай хуулийн заалт нь дээрх хуулийн заалтуудтай зөрчилдөж байгаа нь хэрэгжилтэд саад болж байна. Тэгш хамруулах боловсролын сүлжээний гишүүдийн хийсэн дүн шинжилгээгээр Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн сурч боловсрох эрхийн тухай бүлэгт хөгжлийн бэрхшээлтэй хүн бусад иргэний хамт сурч боловсрох эрхтэй (14.1) бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг бэрхшээлээс нь үл хамааран бүх шатны боловсролд бүрэн хамруулах (14.3.2) тухай заалт нь тэгш хамруулан сургах бодлогод нийцэж байгаа ч хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамруулан сургах бодлого, арга хэмжээний хажуугаар уламжлалт хандлагаар тусгай стандарт, хөтөлбөрөөр, тусгай ангид сургах арга хэмжээ авахаар заасан нь зөрчил үүсгэж байна.

Бага дунд боловсролын тухай хуулийн “Ерөнхий боловсролын тусгай сургууль” гэсэн 13-р зүйлийн 3-т “Ерөнхий боловсролын бусад сургууль нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй.” гэсэн заалт орсон байгаа нь тодорхойгүй байдлыг үүсгэж байгаа юм.

Тэгш хамруулан сургах боловсрол бол хөгжлийн бэрхшээл, бусад шалтгаанаас үүдсэн онцлог хэрэгцээтэй сурагчдыг ердийн сургуульд шаардлагатай дэмжлэгээр ханган амжилттай сургаж, үндэсний стандартад

1 Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, 4-р бүлэг

нийцсэн боловсрол эзэмшүүлэх бодлого билээ.

“Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийг Засгийн газраас 2017 онд баталж, “Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бүх шатны боловсролд тэгш хамруулна.” зорилт тавьж, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө батлан хэрэгжүүлж байгаа нь тэгш хамруулах боловсролын талаарх бодлогын суурийг бэхжүүлсэн.

Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд хамруулах үүрэгтэй бөгөөд энэ үүргээ хэрэгжүүлэхэд сургууль, хорооны нийгмийн ажилтан мэдээллээр хангаж хамтран ажиллах үүрэгтэй (14.4) болжээ. Энэ нь хүүхдээ сургуульд элсүүлэх, үргэлжлүүлэн сургах асуудлаар оролцох, нөлөөлөх эрх мэдэл багатай эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчдэд тун чухал дэмжлэг юм.

2018 оноос эхлэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах чиглэлээр хэд хэдэн эрх зүйн баримт бичгүүд гарсан ч санхүүжилтийн болон зохицуулалтын дутагдалтай байдлаас үүдэн газар дээрээ хэрэгжихгүй байна.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/292 дугаар тушаалаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамран сургах”/ цаашид сургууль/ гэх журмыг батлан гаргасан. Энэхүү журмыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд сургууль, багш нарт хандсан зөвлөмж яамнаас батлан хүргүүлсэн байна. 2018 оны гуравдугаар сард хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах аргачлал, төлөвлөгөөний жишиг шаардлага, үлгэрчилсэн загвар, хэрэглэх зөвлөмж”-ийг салбарын сайдын тушаалаар батлан хэрэгжүүлж байна.

“Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам”-д хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн үнэлгээний талаар цөөн заалт орсон нь тэдний хөгжлийн ахиц, гарч буй өөрчлөлтийг үнэлэх чиглэлд хийгдэж байгаа эхний оролдлого гэж хэлж болно.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг 1) тусгай хэрэгцээт хүүхэд, хүний талаар тахир дутуу, хөгжлийн бэрхшээлтэй (хөгжих саад бэрхшээлтэй буюу бие махбодын хувьд өвчтэй, согогтой гэж ойлгогдохоор) гэж агуулгын хувьд алдаатай орчуулж, хэрэглэж ирсэн, 2) хууль эрх зүйн баримт бичигт хөгжлийн бэрхшээлийг зөвхөн бие махбодын эмгэг, согог талаас нь авч үзсэн (хараа, сонсгол, хэл яриа, оюуны, тулгуур эрхтний бэрхшээлтэй, сэтгэцийн эмгэгтэй болон хавсарсан), 3) иргэд олон нийт төдийгүй салбарын мэргэжилтэн, судлаачдын дунд дээрх хязгаарлагдмал ойлголт байсаар байна.

Иймд ХБХ-ийг боловсролд тэгш хамран сургахын тулд салбар дундын хамтын ажиллагаа нэн чухал байгааг мэргэжилтнүүд тэмдэглэсэн байна. БСШУСЯ болон ЭМЯ, ХНХЯ хамтран хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах чиглэлээр хэд хэдэн чухал удирдамж, зааварчилгааг батлан гаргасан. 2018 оны 11 дүгээр сард Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын хөдөлмөрийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд хамтран “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх заавар, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын шийдвэрийн маягт, хүүхдийн хувийн хэрэг хөтлөх

маягт, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн бүртгэлийн маягт батлах тухай” 0-18 насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хэрхэн цогц дэмжлэгийг үзүүлэх зааврыг хавсралт маягтуудын хамт баталсан. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрт илрүүлэг, хөгжлийн дэмжлэг, боловсролын дэмжлэгийн тогтолцоо, түүнд холбогдох байгууллагуудын чиг үүргийг илтгэсэн чухал баримт бичиг гарсан.

ХБХ-ийн хувьд сургалтын материаллаг орчин байхгүй, тусгай хэрэгцээт боловсрол олгоход чиглэн бэлтгэгдсэн багш, мэргэжилтэн байхгүй, төсөв мөнгө хүрэлцээгүй, хүүхдээ сургуульд хамруулах тал дээр эцэг эхийн оролцоо, сул байна. Боловсролын тухай хуулийн 40.5. заалтад нэг суралцагчид ногдох хувьсах зардлыг хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тусгай хэрэгцээтэй уялдуулан ялгавартай тогтоохоор хуульчилсан ч тусгай сургуулиас бусад сургуульд үйлчлэхгүй байна. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 6 дугаар сарын 01-ний өдрийн хуралдаанаар “Ердийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ганцаарчлан ажиллаж байгаа үндсэн болон туслах багшид тэдний албан тушаалын /үндсэн/ цалингийн 10 хувийн нэмэгдэл хөлс тооцож олгох” шийдвэр гаргасан байна.

Нэг талаар нүдний шил зүүсэн хүүхэд бүр хөгжлийн бэрхшээлтэй гэж үзэх төрийн албан хаагчдын чадавхын асуудал, нөгөө талаас эцэг эхчүүд хүүхдээ хөгжлийн бэрхшээлтэй гэдгийг бүртгүүлэх, мэдэгдэхээс татгалзах хандлагын дунд ХБХ-ийн суралцах эрх орхигдож байна. Монгол Улсад “ХБХ-ий эрхийн тухай” хуулийн 37.2 заалтаар “0-16 насны хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг ХБХ-ийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс (ХБХЭМБНХК) тогтооно” гэжээ. Өнөөгийн байдлаар Монгол Улсын 21 аймаг, 9 дүүрэг тус бүрд дээрх үүрэг бүхий салбар комиссууд байгуулагдан үйл ажиллагаагаа эхлүүлсэн хэдий ч хүүхдийн бэрхшээлийг илрүүлэх, үнэлэх, тодорхойлох нэгдсэн аргачлал хараахан нэвтрээгүй, ялангуяа боловсролын хэрэгцээг үнэлэх комиссын чадавх туйлын хангалтгүй байгаад ИНБ-ууд шүүмжлэлтэй хандаж байна.

3.3 ХЭЛ/ СОЁЛЫН ЯЛГААТАЙ ХҮҮХДИЙГ БОЛОВСРОЛД ТЭГШ ХАМРУУЛАХ БОДЛОГЫН АСУУДАЛ

Хөгжиж буй орнуудад боловсролын чанар доогуур байгаа явдлыг шийдвэрлэхэд анхаарлын төвд байх ёстой асуудал бол хос хэлний сургалтын бодлого боловсруулж хэрэгжүүлэх явдал юм. Бага ангиасаа өөрсдийн эх хэл дээр боловсрол эзэмшиж байгаа хүүхдүүдийн сургалтын үр дүн, ялангуяа, унших бичих чадварын түвшин илүү сайн байдгийг судалгаагаар хангалттай баталсан байдаг.

Альчулсын үндэстний цөөнхийн хүүхдүүдэх хэлнээсээ гадна төрийн албан ёсны хэлийг эзэмших эрх, хэрэгцээ байдаг. Өөрийн хэл соёлыг хадгалах, өвлүүлэх нь эдгээр хүүхдүүдийн хувь хүний суурь эрх болдог бол төрийн албан ёсны хэлийг эзэмших нь үндэстний цөөнхийн хүүхдүүдэд өргөн хүрээтэй нийгмийн харилцаанд оролцох, боловсролыг хүссэн газраа тасралтгүй эзэмших, хөдөлмөрийн зах зээл дээр бусад иргэдтэй ижил тэгш өрсөлдөх боломж олгодог бодит нөхцөл тул мөн л эдгээр хүүхдийн нийгэм, эдийн засаг, хүний

эрхийн асуудал болдог. Тиймээс ч үндэстний цөөнхийн хүүхдүүд 2 хэлээр боловсрол эзэмших онцлог хэрэгцээтэйг хүлээн зөвшөөрч, улс орнууд бага болон суурь боловсролдоо хос хэлний боловсролын стандарт, сургалтын арга зүйг нэвтрүүлдэг. Эх хэлд суурилсан хос хэлний боловсрол нь ялангуяа, алслагдсан, хөдөө орон нутгийн гэх мэт эмзэг бүлгийн хүүхдүүдэд хамгийн ач тустай байдаг. Манай улсын хувьд хос хэлний боловсролын асуудлын хамгийн тодорхой үзэгдэл бол үндэстний цөөнх болох казак үндэстэн Баян-Өлгий аймагт, мөн үндэстний хамгийн цөөнх болох цаатан (тува) хүмүүс Баян-Өлгий аймгийн Цэнгэл сум, Хөвсгөл аймгийн Цагааннуур суманд дагнан амьдардаг явдал юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн 8-р зүйлийн 1-т “Монгол хэл бол төрийн албан ёсны хэл мөн.” 2-т “Энэ зүйлийн 1 дэх хэсгийн заалт нь хүн амын өөр хэл бүхий үндэстний цөөнх эх хэлээрээ суралцах, харилцах, соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах эрхийг үл хөндөнө.” гэж заасан байдаг. Цаашилбал Боловсролын тухай хуулийн 30.1.12-т үндэстний цөөнхийн боловсрол эзэмших, соёл, зан заншлаа өвлөх, сургуулийн орчинд төрөлх хэлээрээ харилцах нөхцөлийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах бүрэн эрхийг аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэхээр тусгасан ч Баян-өлгий аймгаас бусад үндэстний цөөнх амьдардаг аймаг, орон нутагт, тухайлбал, нийслэлийн Налайх дүүрэгт хэрэгждэггүй байна. Монгол хэлний тухай хуулиар Боловсрол, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад суралцагчдын дийлэнх олонх хүн амын өөр хэл бүхий үндэстний цөөнх байвал сургалтыг хос хэлний хөтөлбөрөөр явуулах бөгөөд хос хэлний хөтөлбөрийн агуулгыг батлах үүрэг хүлээлгэсэн ч өнөөдрийг хүртэл хэрэгжээгүй. УИХ-аас баталсан “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого”-д “Суралцагчдын дийлэнх олонх нь хүн амын өөр хэл бүхий үндэстний цөөнх байвал эх хэлээрээ бага боловсрол эзэмших нөхцөл, боломжоор хангаж, хос хэлний сургалтын бодлого, хөтөлбөр хэрэгжүүлнэ.” гэж заасан нь мөн хэрэгжээгүй байна.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2005 оны 387 дугаар тушаалаар “Тува хэлний хөтөлбөр”; Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 425 дугаар тушаалаар “Казак хүүхдийн боловсролыг дэмжих үндэстний хөтөлбөр”-ийг баталсан ч хэрэгжилт туйлын хангалтгүй байгааг үндэстний цөөнх хүүхдийн сургуульд хамрагдалт, сургууль завсардалт, төгсөлт, болон сурлагын чанарын судалгааны дүнгээс харж болно. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын “Сургалтын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай” 2015 оны А/220-р тушаалд Үндэстний цөөнхөд зориулсан хос хэлний боловсролын бодлого, агуулга, хөтөлбөр боловсруулж бэлтгэл ханган 2016-2017 оны хичээлийн жилээс хэрэгжүүлэхээр шийдвэр гарсан нь мөн хэрэгжээгүй байна. Баян-Өлгий аймгийн зүгээс “Хос хэлээр сургалт явуулдаг сургуулийн талаар баримтлах аймгийн бодлого, чиглэлээ” тодорхойлж, түүнийг 2012 – 2016 онуудад хэрэгжүүлэх төлөвлөгөөг гаргасан байдаг. Хос хэлний боловсрол хэмээх энэхүү бодлогын томоохон асуудлыг зөвхөн нэг аймагт хариуцуулсан эрх зүйн зохицуулалтыг эргэн харах шаардлагатай байна. Тус төлөвлөгөөгөөр үндэстний цөөнх казак хүүхдүүд цэцэрлэг болон бага ангидаа бүх хичээлээ

төрөлх хэл дээрээ сурч, суурь боловсролыг төрөлх хэлнээс төрийн албан ёсны хэлэнд аажмаар шилжих үе гэж үзэж 6-8 дугаар ангиас шинжлэх ухааны хичээлүүдийг монгол сурах бичиг ашиглан судлах болсон байна. Харин 10-12-р ангид бүх хичээлийг монгол хэлээр зааж, казах хэл, уран зохиолын хичээлийг заавал сонгон судлахаар зохицуулсан нь казак сургуульд эх хэлээ тусгайлан заах цаг байхгүйг харуулж байна.

Их Британийн Хүүхдийг ивээх сангийн 2005 онд хийсэн судалгааны тайланд бодлого боловсруулагчид тэгш байдлыг зөвхөн үл ялгаварлах, гадуурхах, тодорхой бүлгийг хориглохгүй байх зэргээр харж, харин сурах тэгш боломжоор хангах, сургалтын тэгш үр дүнд хүрэх онцгой хэрэгцээ гэж төдийлөн анхаарахгүй байгааг шүүмжилсэн байна. Манай улсад үндэстний цөөнхийн хүүхдүүдийн хос хэлний боловсролын талаарх үзэл баримтлал гараагүй байгаа тул хэрэгжүүлэгчдийг буруутгах үндэслэл үгүй бөгөөд үндэстний цөөнхийн боловсролд тулгамдаад байгаа бүх асуудлын суурь шалтгаан энэ байх магадлалтай. Цаашилбал багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх, сургалтын хөтөлбөр, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн зэрэг олон асуудлууд шийдлээ хүлээж байна.

Хос хэлний боловсролын асуудал нь боловсролыг илүү тэгш хамруулсан байдлаар хөгжүүлэх, бүх нийтийн сурч боловсрох эрхийг хангахад чиглэгдсэн улс төрийн чин хүсэл эрмэлзэл байхад хэрэгждэг.

3.4 ЖЕҮДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛ БОЛОН ҮЕ ТЭНГИЙН ДАРАМТ, ДЭЭРЭЛХЭЛТЭД ӨРТСӨН ХҮҮХДҮҮДИЙГ БОЛОВСРОЛД ТЭГШ ХАМРУУЛАХ БОДЛОГЫН АСУУДАЛ

Төрөөс боловсролын талаар баримтлах бодлогод “Боловсролын байгууллагын орчинд суралцагчийг эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн сөрөг үзэгдлээс хамгаалах нөхцөл, боломжийг бүрдүүлнэ.” Мөн “Боловсролын салбарт жеңдэрийн тэгш байдлыг хангах бодлого боловсруулж, үе шаттай хэрэгжүүлнэ.” гэсэн зорилтууд туссан.

2018 оноос эхлэн “Ерөнхий боловсролын сургуулийн орчин дахь Хүүхэд хамгааллын бодлого”, “Боловсролын байгууллагын сургалтын орчин ба дотуур байранд хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх журам”, “Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг суурь боловсролын үйлчилгээнд тасралтгүй хамруулах журам” зэрэг боловсрол, сургалтын орчин, дотуур байранд хүүхдийн эрхийг хангах, аливаа хэлбэрийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүчирхийлэлд өртсөн хүүхдийн сурч боловсрох эрхийг хангах олон чухал баримт бичгүүд батлагдан хэрэгжиж эхлээд байна. Гэвч эдгээр дүрэм журмууд сургууль дээр хэрэгжихэд бэрхшээл учирсаар байна. Хүүхдийг хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, оролцогч талуудын мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх сургалтын удирдамж, орчны үнэлгээний аргачлал зэрэг мэргэжлийн удирдамж зөвлөмж дутагдалтай, сургууль дээр хийгдэх хүүхэд хамгааллын чиглэлээрх үйл ажиллагааны зардал төсөвт тусаагүй байна.

2018 онд “Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, албан бус, насан туршийн боловсролын төвийн багш, удирдах болон бусад ажилтны ёс зүйн

дүрэм"-ийг шинэчлэн баталсан бөгөөд Монгол Улсын нутаг дэвсгэрт сургалтын үйл ажиллагаа эрхэлж буй өмчийн бүх хэлбэрийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, албан бус, насан туршийн боловсролын төвийн багш, туслах багш, удирдах болон бусад ажилтан /цэцэрлэгийн арга зүйч, нийгмийн ажилтан, дотуур байрын багш, номын санч, эмч/ дагаж мөрдөхөөр заасан нь ач холбогдолтой. Энэхүү ёс зүйн дүрэмд ялгаварлан гадуурхалтаас сэргийлэх чиглэлээр 2 чухал заалт орсон юм. Хүүхдийг гэр бүлийн байдал, хөгжил, суралцах чадвараар нь ялгаварлахгүй байх, эцэг, эх, асран хамгаалагчийг нас, хүйс, хувийн онцлог, албан тушаал, мэдлэг, туршлагаар нь ялгаварлахгүй байхыг үүрэг болгосон. Мөн сургууль, цэцэрлэгийн орчинд хүүхдийн эрүүл мэнд хохирох, бэлгийн дарамтад өртөх, үе тэнгийнхэн болон гадаад орчин, цахим орчны сөрөг нөлөөнд автахыг анхаараагүйгээс тэдний эрх, эрх ашиг хохирох байдалд хүргэхээс сэргийлэх, хүүхэд, гэр бүл, эцэг, эх, асран хамгаалагчтай холбоотой мэдээллийн нууцыг хадгалах үүргийг мөн оноосон.

Харамсалтай нь "Багшийн ёс зүйн дүрэм"-ийн хэрэгжилт хангалтгүй байгаагийн шалтгаан нь ажил олгогч энэхүү ёс зүйн дүрмийг багш, удирдах болон бусад ажилтанд танилцуулж, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээ авах үүргээ биелүүлдэггүй, төсөвт үйл ажиллагааны зардал тусаагүй, хяналт мониторинг хийдэггүй, аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх ёс зүйн зөвлөлийн гишүүдийг ёс зүйн дүрмийг зөрчил, ёс зүйн зөрчил гаргасан эсэхийг тогтоох, зохих журмын дагуу шалгалт хийх зэрэг чадавхыг бэхжүүлээгүйтэй холбоотой.

Хүний эрхийн үндэсний комиссын илтгэлээс харахад гэр бүлийн хүчирхийлэл жилээс жилд өсөж байгаа ба 2017 оны байдлаар гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдын зургааны нэг хувь нь 18-аас доош насны хүүхэд байгаа бөгөөд Хүүхдийн төлөө үндэсний газар (ХТҮГ)-т аймаг, сум, баг болон дүүргээс ирсэн тайланд олон тооны хүүхэд сэтгэл зүйн асуудалтай байгаа болон энэ чиглэлээр хүүхдүүдэд үйлчилгээ үзүүлэх орон нутгийн ажилтнуудын чадавх хангалтгүй, мэргэжлийн сэтгэл зүйч шаардлагатай байгаа талаар дурджээ. Жендэрт суурилсан хүчирхийллийн нэг хэлбэр болох сургууль дээрх дарамт, хүчирхийлэл нь багш болон бусад сурагчдын зүгээс дээрэлхэх, хүчирхийлэх үйлдэл юм. Монгол Улсын хууль тогтоомжоор сургуулийн орчинд бие махбодын шийтгэлийг хориглосон билээ. Боловсролын тухай хуулийн 44-р зүйлийн 3 дахь хэсэгт багш нь суралцагчийн бие махбодод халдах, сэтгэл санааны дарамт үзүүлэх, хувийн нууцыг нь задруулахыг хориглоно гэж заасан байдаг ч энэхүү заалтын хэрэгжилт тунхгийн шинжтэй байгаагаас нь болж сургуулийн орчинд, багш хүүхдийг сэтгэл санааны хувьд хүчирхийлэх явдал амь бөхтэй оршин тогтносоор байна гэдгийг хүний эрхийн байгууллага онцолсоор байна.

Нийслэлийн Хүүхэд, гэр бүл хөгжлийн газраас 2014 онд хийсэн "Хүүхдийн хүчирхийлэлд өртөж буй байдал-2014" судалгаанд хамрагдсан охидын 15.0 хувьд нь тэдний эмзэг газар болох хөх, бэлэг эрхтэнд хүрч, биедээ албаар хүргэх, хөвгүүдийн 13.5 хувьд нь хэн нэгэн түүнд бэлгийн харилцааны талаар бичиж, ичээж зовоох зэрэг бэлгийн хүчирхийлэл үзүүлж байсан гэжээ. Мөн 2015 онд Нийслэлийн 9 дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн төвд хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн 16 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд 2016 оны 1

дүгээр улирлын байдлаар 19 тохиолдол бүртгэгдсэн нь энэ төрлийн хүчирхийлэл эрс нэмэгдэж байгааг Улсын ерөнхий прокурорын газрын судалгаа харуулж байна. Түүнчлэн өсвөр нас нь хүүхдийн бие болоод сэтгэл зүйн хувьд асар их өөрчлөлт, хямралыг даван туулж, бие хүн болон төлөвших, нийгэмд байр сууриа олох шилжилтийн эмзэг үе байдаг билээ. Тиймээс бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд онцгой анхаарал хандуулан, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн сэтгэл зүйн үйлчилгээ, сэтгэл заслын эмчилгээг үр дүнтэй хийх, хүний нөөцийг чадавхжуулах хэрэгцээтэй байна. Хэдийгээр хүүхдэд учирсан бие махбод, сэтгэл санааны хохирлыг нөхөн сэргээх, эргээд хэвийн амьдралдаа ороход нь дэмжлэг үзүүлэх эрх зүйн зохицуулалт байгаа хэдий ч энэ нь бодит амьдрал дээр хэрэгждэггүй, хуулиар үүрэг хүлээсэн байгууллагуудын үйл ажиллагаа хангалтгүй, харилцан уялдаа холбоогүйгээс гадна гэмт хэргийн хохирогч болсон хүүхдийн эрсдэлийг тооцон хүүхэд бүрд тохирсон хамгаалалт, эрүүл мэндийн болон нийгмийн үйлчилгээ үзүүлэх тусгайлсан механизм байхгүй байна. Мөн шүүхэд сэтгэл санааны хохирлыг тооцох аргачлал нь хангалтгүй, бэлгийн хүчирхийллийн хохирогчдод чиглэсэн сэтгэл засах, нийгэм, хамт олны дунд оруулах үйлчилгээ байхгүй, хэрэг шалгаж, шийдвэрлэх явцад хохирогчийн хувийн нууцыг хамгаалах асуудал дутагдалтай, нэр хүндэд нь халдах явдал их байна. Хүүхдүүд бэлгийн хүчирхийлэлд өртөөд зогсохгүй байнгын бэлгийн дарамтад байх, улмаар өсвөр насандаа хүүхэд төрүүлэх, бэлгийн замаар дамжих халдварт өвчнөөр өвчлөх явдал гарсаар байна.

Өсвөр насандаа жирэмсэлж хүүхэд төрүүлэх нь охидын хувьд эрүүл мэнд, нийгэм, сэтгэл зүйн болон эдийн засгийн олон бэрхшээлтэй асуудлуудыг дагуулж байдаг. Тухайлбал, хүсээгүй жирэмслэлтээс үүдэлтэй сэтгэл гутрал, биеийн эрүүл мэнд, сурч боловсрох, амьдрах гээд олон эрх нь зөрчигдөж хохирдог. Үүнээс гадна хүүхэд төрүүлсэн охид маш их ялгаварлан гадуурхалтанд өртдөг. Эцэг эх, төрөл садан, багш, эмч, найз нөхдийн зүгээс хүсээгүй доромжлол, дээрэлхэлтэнд өртдөгөөс гадна төрүүлсэн хүүхдийнх нь ч эсрэг үзэн ядалтууд нь сэтгэл зүйн гүн цочрол руу түлхдэг нь нууц биш юм. Ингэж бие сэтгэл, эрүүл мэндээрээ хохирсон охид хүүхдээ ч хэрхэн асарч хүн болгохыг мэдэхгүй, цаашид амьдрах итгэлээ ч алдаж өөрийгөө нийгмээс бүрэн тусгаарласан байдаг. Ихэнх нь эцэггүй хүүхдээ ганцаараа өсгөх болдог. Ажил эрхлэх боломжгүй учир орлогогүй, улмаар ядууралд өртөж өөрөө болон хүүхэд нь хоол тэжээлийн дутагдалд орох, наад захын хэрэглээгээ хангаж чадахгүй байдаг гээд тэдэнд тохиолддог олон бэрхшээлүүдийн талаар сэтгэл эмзэглүүлсэн жишээнүүд олон байна.

Охид, залуу эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах “Гүнж” төвөөр 2016-2017 оны хооронд үйлчлүүлсэн 51 өсвөр насны эхчүүдийн 11 нь буюу 21.6% сургууль завсардсан байна. Эдгээр охидын,

- ✓ 36.4% нь хүүхдээ төрүүлсний дараа өөр сургуульд шилжин суралцсан,
- ✓ 36.4% нь өөрсдөө үргэлжлүүлж суралцахыг хүсээгүй,
- ✓ 18.2% нь огт сургуульд сурч байгаагүй,
- ✓ харин 1 охин найз хөвгүүний хамт “бусад сурагчдад муу үлгэр дууриалал

үзүүлсэн” гэх шалтгаанаар сургуулиасаа хөөгдсөн байна.

“Өсвөр үеийнхний дуу хоолой” судалгаанд оролцсон хүүхдүүдийн 15.4% нь бусдад дээрэлхүүлж доромжлуулах вий гэж санаа зовдог гэсэн бөгөөд хөвгүүдийн хувьд энэ тоо охидоос өндөр² байна. 2015 онд Хүн амын хөгжил, Нийгмийн хамгааллын яам, ЖАЙКА, ХИС хамтран хийсэн “Хүүхэд хамгааллын хамтарсан багийн өнөөгийн байдал” судалгаанд оролцогчдын 44,7% нь сургуулиа “айж эмээх зүйлтэй, айдастай орчин” гэж үнэлсэн бол 2016 онд хийсэн “Хүүхдийн эрх, хамгаалал үндэсний судалгаагаар” (38,3% нь сургуулийн орчноос, тухайлбал, багш, сургуулийн атаман, нийгмийн ажилтан, дотуур байрны багшаас хамгийн их айдаг)³ үүнийг баталгаажуулсан дүн гарчээ.

Дотуур байранд хүүхдийн эрүүл, аюулгүй, хүчирхийлэлгүй орчин бүрдээгүй хүүхдийн хамгаалагдах эрх хангагдахгүй байгааг удаа дараа хийсэн судалгааны дүн нотолж байгаа ба хамгийн сүүлд хийгдсэн судалгаа нийт дотуур байрны 76.2%-д хүүхдүүдийн дунд бие биенээ дээрэлхэх явдал их, бага ямар нэг хэмжээгээр байгааг⁴ харуулжээ.

Гэтэл өсвөр үеийнхэн, тэдний эцэг эхчүүд хүүхэд хамгааллын тогтолцооны талаар мэдлэггүй, хүчирхийллийн тохиолдол гарахад хаана хандахаа мэдэхгүй байгаа төдийгүй албан ёсны үйлчилгээ үзүүлэгчдэд хандахыг ч хүсэхгүй байгааг Дэлхийн зөн монгол байгууллагын судалгаа харуулж байна. Өсвөр үеийнхэн насанд хүрэгчид тэдний асуудлыг сонсоно, зохих ёсоор шийднэ, тэдний нууцыг хадгална гэдэгт итгэхгүй байгаагаа бүлгийн ярилцлагын үеэр⁵ илэрхийлжээ.

3.5 ТЭГШ ХАМРУУЛАХ БОДЛОГЫН БУСАД АСУУДЛУУД СУРГУУЛЬ ЗАВСАРДАЛТЫН АСУУДАЛ

Сургууль завсардалтын байдалд төрийн болон орон нутгийн бодлогын түвшинд анхаарахгүй байна. Хотын зах орчмын дүүргүүд болон судалгаанд хамрагдсан сум, орон нутагт ЕБС-д огт суралцдаггүй хүүхдийн албан ёсны нэгдсэн судалгаа хийгдээгүй байгааг анхаарч, төрийн анхан шатны байгууллага болох баг, хорооны түвшинд нарийвчилсан судалгаа хийх шаардлагатай.

ҮСХ-ноос гаргасан мэдээллийг⁶ харвал 2018-2019 оны хичээлийн жилд бага боловсролд хамрагдвал зохих 6-10 насны нийт хүүхдийн 5,5% буюу 15.3 мянган хүүхэд, дунд ангид хамрагдвал зохих 11-14 насны нийт хүүхдийн 7,4% буюу 13.8 мянган хүүхэд сургуульд хамрагдаагүй байна. Үүнээс эрэгтэй 56%, эмэгтэй 44% байна. Сургуульд хамрагдаагүй 29.152 хүүхдийн хэд нь суралцах боломжгүй хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй, хэд нь ямар учир шалтгааны улмаас завсардаад буйг харах боломжгүй байгаа юм.

ЕБС-ийн гадна байгаа хүүхдүүдийн шалтгааныг тодорхойлдог аргачлал

- 2 “Өсвөр үеийнхний дуу хоолой” судалгаа, ХИС, 2017 он
- 3 ХЭҮК, Гүүд нэйборс олон улсын байгууллагын монгол дахь төлөөлөгчийн газар хамтран КАП аргачлалаар хийсэн
- 4 “Сургуулийн дотуур байрны орчин нөхцөл, хүүхдийн хөгжил хамгааллын байдал” судалгаа, МУБИС, Нийгмийн ажил, аргазүйн тэнхим, 2017 он
- 5 LEAP 3 Baseline Report, World Vision Mongolia, 2018
- 6 Суурь судалгааны тайлан, ҮСХ, Жендэрийн үндэсний хороо, 2020 он, 53 дахь тал

учир дутагдалтай бөгөөд амьдралын гачигдлаар, суралцах хүсэлгүй, ажил эрхлэхээр, өвчний улмаас, шалтгаан тодорхойгүй гэсэн үндэслэлээр сургууль завсардсан эсвэл огт элсээгүй гэж тоон мэдээллийг гаргадаг нь байна. Сургууль завсардалтын шалтгааныг тодорхойлохдоо зөвхөн хүүхдийн нөхцөл байдлаас болсон мэт гаргаж байгаа нь тэгш хамруулах зарчимд нийцэхгүй байна.

Мөн бодлогын хувьд сургуулийн насны боловч сургуульд хамрагдахгүй байгаа хүүхдүүдээс гадна бага ба дунд боловсролын түвшинд завсардах эрсдэлтэй хүүхдүүдийг тодорхойлж, боловсролын гадуурхалд хүргэж байгаа саад тотгоруудтай холбож харвал тэдэнд чиглэсэн бодлогын чиглэл, авах арга хэмжээнүүд тодорхой болно.

Мөн зарим олон улсын байгууллагууд маргиналчлагдсан хүүхдүүдийг тулгарч буй саад тотгорын байдлаас шалтгаалан “хүрч очиход амархан, хүрч очиход хэцүү, хүрч очиход хамгийн хүнд хүүхдүүд” гэсэн 3 категорит ангилж үзсэн байдаг.

Хүрч очиход амархан хүүхдүүд	Хүрч очиход хэцүү хүүхдүүд	Хүрч очиход хамгийн хүнд хүүхдүүд
<p>Тодорхойлоход хялбар, цөөн тооны саад тотгор байгаа тул амархан хүрч очиж, сургуульд хамруулж болно.</p> <p>Нэг шинж чанар бүхий хүн амын бүлэг байх бөгөөд эрэлт нийлүүлэлтийн талын 1-2 саад тотгор тулгардаг байх магадлалтай. Тухайлбал, нийгэм-эдийн засгийн статус доогуур өрхийн хүүхэд байвал дүрэмт хувцас, сурах бичиг, 4 улирлын хувцас, хичээлийн хэрэгслийг худалдан авч өгөх, үдийн хоол хөтөлбөрт хамруулах, эцэг эхийн оролцоог хангах замаар дээрх саад тотгоруудыг арилгаж болно.</p> 	<p>Эдийн засаг, нийгмийн хүчин зүйлүүд давхардан үйлчилж байгаа үед асуудлыг шийдэхэд амаргүй, хүүхдэд хүрч очиход хүнд хэцүү байх тохиолдол.</p> <p>Тухайлбал үндэстний цөөнхийн төлөөлөл болсон малчин өрхийн хүүхэд байвал дэд бүтцийн, хандлагын, ядуурал, мал маллахад туслах үүрэг гэх мэт шийдвэрлэхэд хүнд эрэлт, нийлүүлэлтийн олон тооны хийгээд шийдэхэд хүнд саад тотгорууд байна гэсэн үг.</p> 	<p>Нөхцөл байдал, нийгэм, эдийн засгийн сүлжилдсэн ярвигтай хүчин зүйлийн улмаас хувь хүн рүү нь чиглэсэн эрэлт хэрэгцээнд нь тааруулсан арга хэмжээ тусгайлан авах шаардлагатай хүүхдүүд.</p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй охид, хүүхэд төрүүлсэн охид зэрэг багтана.</p> 

Харин энэ судалгаанд хамрагдсан оролцогчдын мэдээллээр дараах байдлаар ангилж үзэж болохоор байна.

Хүснэгт 10. Хүүхдийн сургууль завсардалтын нийтлэг шалтгаан

Нийслэл дэх сургууль завсардалтын шалтгаан	Аймгийн төв, сумд дахь сургууль завсардалтын шалтгаан
<ol style="list-style-type: none"> 1. Амьжиргааны түвшингийн дорой байдал 2. Шилжих хөдөлгөөн, бүртгэл хийгдээгүйгээс 3. Хөгжлийн бэрхшээлийн улмаас 4. Багш нарын ялгаварлал, дарамт шахалтын улмаас 5. Эцэг эхийн хандлага, хариуцлагагүйгээс 	<ol style="list-style-type: none"> 1. Хөгжлийн бэрхшээлийн улмаас 2. Амьжиргааны түвшингийн дорой байдлаас 3. Газар зүйн байршил алслагдмал байдлаас 4. Эцэг эхийн хандлага, хариуцлагаас

Бодлого, хөтөлбөр боловсруулахад орон нутаг, иргэдийн оролцоо

Түүнчлэн судалгаанд хамрагдсан дүүрэг, аймаг, орон нутгийн удирдлагын түвшинд хэрэгжүүлж буй бодлого, хөтөлбөрөөс тэгш хамруулах боловсролын хэрэгжилт ихээхэн хамаарч буйна. Мэргэжилтнүүдийн үзэж байгаачлан удирдлагууд хуралдаж, бодлого хөтөлбөр батлан гаргаад үүнийгээ хэрэгжүүлсэн тайлан өг гэхээсээ илүү бодлого, хөтөлбөр гаргахдаа тухайн нэгж дээр ажиллаж буй хүмүүсээс санал авах, эсвэл боловсролоос тусгаарлагдах эрсдэлд байгаа тухайн хүүхдийг оролцуулж, олон тал хэлэлцүүлэг хийн санал авах, туршилт хийсний үндсэн дээр хэрэгжүүлэх нь чухал юм.

Төрөөс боловсролын талаар баримтлах бодлогод “Боловсролын хөгжлийн стратегийг тодорхойлох, нийтлэг зохицуулалт хийхэд зөвлөх эрх бүхий мэргэжлийн гишүүдээс бүрдсэн боловсролын зөвлөлийг байгуулж, тогтвортой ажиллуулах”, “боловсролыг хөгжүүлэх бодлого, стратеги, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл боловсруулах, хэрэгжүүлэхэд бодлого боловсруулагч, хэрэгжүүлэгч, мэргэжлийн холбоо, эрдэм шинжилгээний байгууллага, судлаач, иргэний оролцоог хангах”, заалтууд хэрэгжсэнгүй өнөөг хүрлээ.

ХЗДХЯ, ШХА-гаас 2017 онд хийсэн “Монгол улсын хуулиуд дахь иргэний оролцооны талаарх зохицуулалтын хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ” судалгаагаар боловсролын салбарт оролцогч талуудын оролцоо хангалтгүй байгааг илрүүлсэн. Иргэний оролцоог идэвхтэй, зөвлөлдөх, мэдээллээр хангах, хяналт тавих, болон бусад гэсэн 5 хэлбэрээр авч үзээд, иргэний оролцооны хамгийн гол шинж болох шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцох боломж гэсэн шалгуур тавихад боловсролын салбар хангалтгүй гэдэг үнэлгээ авсан. Тухайлбал, иргэдийг оролцуулахыг “үүрэг болгосон бус” оролцуулж “болно” гэсэн хэрэгжилтийг байгууллага, албан тушаалтны үзэмжийн асуудал болгосон заалтууд байгаа юм.

Боловсролын салбарт шийдвэр гаргах ажиллагаанд иргэдийг идэвхтэй


оролцуулах хэлбэр үгүй, зөвлөлдөх оролцоог боловсролын сургалтын байгууллагын дэргэдэх удирдах зөвлөл, сургууль, цэцэрлэгийн зөвлөл, мэргэжлийн боловсрол, сургалтын үндэсний зөвлөл зэргээр тусгасан байна. Гэвч иргэд, иргэний нийгмийн байгууллагын төлөөллөөр хэнийг, хэрхэн сонгох, хэдий хугацаанд өөрчлөх, тавих шалгуур шаардлага байхгүй, журамгүй, санхүүжилтгүй, чиг үүрэг нь тодорхойгүйгээс иргэний төлөөлөл орлоо ч зөвлөл нь тогтмол, бүрэн ажиллаж чадахгүй байна. Боловсролын тухай хуулийн 27.3-т “аймаг, нийслэлийн боловсролын газрын дэргэд тухайн нутаг дэвсгэрт явуулах боловсролын үйл ажиллагааны бодлого, хөгжлийн төлөвлөлтийн асуудлаар зөвлөх чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл ажиллана” гэж заасан. Гэвч энэ зөвлөлийн бүрэлдэхүүний тухай, ямар этгээд, хэрхэн байгуулах, ажиллах хугацаа зэргийг зохицуулаагүй тул өнөөг хүртэл огт байгуулаагүй, үйл ажиллагаа явуулаагүй байна.

Боловсролын тухай хуулийн 21.5-д заасан Сургуулийн дүрмээр үндсэн үйл ажиллагааны хүрээнд эцэг эх, асран хамгаалагч болон бусад байгууллага, иргэдтэй харилцах хэм хэмжээг тодорхойлж батлах, хэрэгжүүлэх шаардлагатай байна.

2019 онд БСШУСЯ-аас “ЕБС-ийн үйл ажиллагаанд эцэг эх, асран хамгаалагч, иргэд, олон нийтийн оролцоо, хариуцлагыг нэмэгдүүлэхэд баримтлах үлгэрчилсэн чиглэлийг” батлан гаргаж, боловсролын үйлчилгээний чанар, хүүхдийн хөгжил төлөвшилтийг дэмжихэд талуудын оролцоо хариуцлагыг нэмэгдүүлэх бодлого баримталж байна.

Мөн 2019 онд БСШУСЯ-аас “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааг үнэлэх журам”-ыг батлан гаргаснаар сургууль дэвшүүлсэн зорилгодоо хүрч буй эсэх, хэрэгжүүлж буй үйл ажиллагааны чанар, ялангуяа хүүхдэд үзүүлэх үйлчилгээний чанар, аюулгүй байдал, нийцлийг баримт нотолгоонд тулгуурлан хамтын оролцоотой үнэлж, байгууллагын түвшинд сайжруулах шаардлагатай асуудлыг илрүүлэх өөрийн үнэлгээг хийж байхаар зохицуулсан байна. Үнэлгээний дүн, дүгнэлтээр цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагаанд нэн тэргүүнд сайжруулах шаардлагатай гэж үзсэн арга хэмжээг тусгасан төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлснээр сургууль тасралтгүй өөрийгөө сайжруулах нөхцөл бүрдэхээр байна.

Дээрх баримт бичгүүд хэрэгжсэнээр сургууль дээр тогтсон хуучин практикийг өөрчлөх, сургуулийг хүүхэд төвтэй байгууллага болгох, хамтын удирдлагын шинэ соёлыг төлөвшүүлж, хүүхэд хөгжиж төлөвших, эрх нь хангагдах, хамгаалагдах нөхцөл бүрдэнэ гэж харж байна.



Төсөв, санхүүжилтийн асуудал

Сургууль гэр хооронд явах замд архи худалдаалах цэг олон, хулгай дээрэмд өртөх эрсдэлтэй, гудамж талбай гэрэлтүүлэг байхгүй гэх мэт хүүхдэд ээлгүй, аюултай орчин нөхцөл байсаар байна. Энэ талаар судалгаа хийгдсэн талбарт Засаг даргын бодлого мөрийн хөтөлбөр, ИТХ-ын бодлого, үйл ажиллагаанд зарим талаар тусгаж байгаа ч орон нутгийн төсөвт тухайн чиглэлд хөрөнгө мөнгө хуваарилдаггүй, зөвхөн донор байгууллагуудын санхүүжилт төсөл хөтөлбөрийг хүүхдийн амжилттай сурах, аюулгүй таатай амьдрах орчныг бүрдүүлэхэд чиглүүлж ажилладаг, тухайн асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн төсөв хуваарилахад хойрго хандах явдал ажиглагдаж байна.

Маргиналчлагдсан, эмзэг бүлгийн хүүхдийг боловсрол эзэмшихэд санхүүгийн саад тотгорууд тулгарч байна. Энэ нь боловсролын төсөв хүүхдийн ялгаатай байдалд мэдрэмжгүй, эрх тэгш байдалд суурилагагүй байгаатай холбоотой.


Хамран сургах тойргийн хүүхдүүдийг сургуульд бүрэн хамруулахад чиглэсэн сум орон нутгийн бодлого шийдвэрийг хэрэгжүүлж, шийдвэрлэх шаардлагатай бодлого, төсвийн асуудлыг дээд түвшний төрийн байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлэх, төрийн захиргааны төв байгууллагууд дороос ирсэн саналд хариу үйлдэл үзүүлэх зэргээр бүх шатны төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах хэрэгтэй болохыг тэмдэглэж байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, САНАЛ

Тэгш хамруулан сургах боловсрол нь ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг халан, суралцагчдын харилцан адилгүй байдал, ялгаатай хэрэгцээ чадвар, онцлог шинж, сурах хүсэл эрмэлзлийг нь хүндэтгэн үзэж бүх нийтэд чанартай боловсрол олгоход чиглэсэн үйл явц юм. Хүн болгон өөрийн гэсэн онцлог шинж чанар, сонирхол болон сурах хэрэгцээтэй учраас тухайн хүний бие бялдар, оюун ухаан нийгмийн сэтгэл зүй, хэлний болон бусад нөхцөл байдлаас үл шалтгаалан амжилттай суралцах эрхтэй. Энэ үйл явцын хүрээнд боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх, суралцах, хөгжих үйл явцад оролцох, үр дүнтэй суралцах эрх тэгш байдлыг хангах, сургалтын чанар, үр өгөөжийг дээшлүүлэх, хүүхэд хөгжил хамгааллын үйлчилгээний хүрээг өргөтгөх, хэрэгжүүлэх арга замыг сайжруулах, сурах орчинд хөрөнгө оруулах шаардлагатай байна.

Тэгш хамруулан сургах боловсрол нь нэг талаас хүн бүрийн онцлог хэрэгцээнд нийцэхүйц, нөгөө талаас тэгш хамруулах сургалтын үйл ажиллагааг явуулах зохицуулалтыг хийх, тухайн хүүхдэд тулгарч буй аливаа саад тотгорыг арилгахад чиглэнэ. Тухайлбал, боловсрол, сургалтын үр дүн тухайн хүүхдийн ар гэрийн байдал, эцэг эхийн боловсролын түвшин, үндэс угсаа хэл соёл, хөгжлийн бэрхшээл, боловсролын орц чанар зэрэг тухайн хүүхдээс өөрөөс нь хамаарахгүй хүчин зүйлсийн нөлөөнд байх ёсгүй юм. Нийгэм, эдийн засаг, нөхцөл байдлын олон талт, зарим үед давхацсан хүчин зүйлүүдийг судалж тогтоон бүлгийн хэмжээнд, заримдаа хувь хүүхдэд чиглэсэн тэгш хамруулах арга хэмжээнүүдийг бодлого, төсвийн хувьд авах шаардлагатай байна.

График 2. Хүүхэд боловсролоос тусгаарлагдах үндсэн шалтгаан



Тэгш хамруулах боловсролыг хэрэгжүүлэх явцад үүнийг зөвхөн нийгмийн маргиналь бүлгийн эрх ашигт төвлөрсөн зарчим мэтээр хязгаарлагдмал утгаар ойлгох, хэрэглэх явдал түгээмэл бий. Үнэн хэрэгтээ энэ нь зөвхөн тодорхой нэг бүлгийн асуудлыг хөндсөн бус, бүх нийтэд боловсролыг хүртээмжтэй болгоход чиглэсэн хүмүүнлэг, хүний эрхийг дээдэлсэн үзэл санаа, зарчим билээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16.11-д “Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална” гэж заасан боловч бодит амьдрал дээр энэ заалтын хэрэгжилт хангалтгүй, нэн ялангуяа ядуу өрхөд амьдарч буй хүүхдийн боловсрол эзэмшихэд нөлөөгүй, хэрэгжихгүй байна. Хүүхдүүдтэй хийсэн кейс судалгааны үр дүнгээс үзэхэд өнөөгийн маргиналчлагдсан бүлгийн хүүхдүүд боловсролоос тусгаарлагдах олон талын эрсдэлд байна.

Хүүхэд өрхийн ядуурал, амьжиргааны тааруу нөхцөл, мөнгө санхүүгийн бэрхшээлээс үүдэж суралцаж, боловсрол мэдлэг эзэмшиж чадахгүй, улмаар урт хугацаанд үе дамжсан, архаг ядууралд өртөхөөр байна. Ядуу өрхөд амьдарч буй хүүхдийн боловсролоос тусгаарлагдах эрсдэлт байдал нь эцэг эхийн ажил мэргэжилгүйн улмаас хөдөлмөр эрхлээгүй, орлого олох чадамжгүй, архинаас хамааралтай болсон, үр хүүхдэдээ тавих анхаарал халамж сул зэрэг хүчин зүйлсээс шууд хамаарч байна.

Ядуу, амьжиргааны түвшин тааруу өрхүүд хүүхдийн хоол хүнс, хувцас, байр, унааны болон бусад зардлыг төлж чадахгүй байгаагаас хүүхдээ сургуулиас завсардуулах тохиолдол гарч байна.

Хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй байх нь түүний хэвийн суралцахад олон талаар саад тотгор болж байна. Хүүхдэд тулгарч буй үйлдлийн бэрхшээлийн төрлүүд тухайн хүүхдийн сурч боловсрох хэрэгцээнээс давсан нөхцөлийг шаардаж буйн зэрэгцээ өдөр тутамд тулгарч буй саад бэрхшээлийг эцэг эх, асран хамгаалагчдын зүгээс шийдвэрлэх чадамж, бололцоо, нөхцөл байхгүй. Нөгөө талаар ХБХ-ийн тусгай хэрэгцээг хангах дэд бүтэц, сургуулийн гадаад, дотоод материаллаг орчин хангалтгүйн зэрэгцээ багш, эцэг эх, үе тэнгийнхний хандлага, дарамт шахалт тухайн хүүхэд “хэвийн” суралцахад тээг, саад болж байна.

ЕБС-ийн багш нарт байвал зохих ур чадварын талаар холбогдох хуулинд тусгасан боловч тухайн хуулийн заалт болон сургууль дээрх багш нарын бодит үйл ажиллагаа ихээхэн зөрүүтэй, багш нар ХБХ-тэй ажиллахад бэлэн биш байна. Сургууль дээр нэмэлт дэмжлэг, үйлчилгээг үзүүлэх мэргэжилтнүүдийн хүрэлцээ хангамжийг нарийн судлах, бүх багшийг тэгш хамруулах боловсролын чиглэлээр бэлтгэх, багш бэлтгэх сургуулиудын сургалтын хөтөлбөрийг эргэн харж хүүхдийн ялгаатай байдал, сурах эрэлт хэрэгцээнд нийцсэн боловсрол сургалтын үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, үнэлэх, сайжруулах арга барилд сургах, сургалт, төлөвшилтийн үйл ажиллагаанд эцэг эхийн оролцоог хангах ур чадварт суралцаж төгсөх нь нэн чухал байна.

Боловсролын үр өгөөжийг хүртэхэд хөгжлийн бэрхшээлтэй хүнд шаардлагатай мэргэжлийн болон бие бялдар, сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх, хоол тэжээл, материаллаг орчинг бий болгохыг чухалчилж, хүн нэг бүрийн хэрэгцээнд нийцүүлэн боловсролын үзэл хандлага, сургалтын орчин багшлахуйн арга зүй,

харилцааг өөрчлөхөд чиглэх ёстой билээ.

Судалгаанд хамрагдсан талбаруудыг авч үзэхэд ЕБС-ийн сургуулийн насны бүх хүүхэд сургуульд бүртгэлтэй боловч амьжиргааны түвшин, хөгжлийн бэрхшээл, шилжих хөдөлгөөн бүртгэл, газарзүйн байршил, эцэг эхийн хандлага, хариуцлага зэрэг тодорхой шалтгааны улмаас сургууль завсардсан байна. Нийгмийн ялгаатай бүлгийн хүүхдүүдийн сурч боловсрох үйл явцыг дэмжих, сайн сайхан байдлыг хангахын тулд эцэг эхчүүдийг ажилтай болгох, архидалттай тэмцэх, бүх төрлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, багш нарын хүүхэд хамгаалал, тэгш хамруулах боловсролын талаар мэргэжлийг дээшлүүлэх, сургалтад түлхүү хамруулах нь чухал болохыг мэргэжилтнүүд онцолж байна.

Судалгааны үр дүнгээс үзэхэд тэгш хамруулах боловсролыг зөвхөн “Бие махбодын бэрхшээлтэй, эмгэг согогтой хүүхдийг ердийн сургуульд хамруулах” гэдэг хязгаарлагдмал ойлголттой, тэгш хамруулах боловсролын үзэл санаа, зарчмыг бүрэн дүүрэн хүлээн зөвшөөрөөгүй, бэлэн биш байгаа нь нотлогдож¹ байна. Тэгш хамруулан сургах боловсрол нь ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг халж, суралцагчдын харилцан адилгүй байдал, ялгаатай хэрэгцээ чадвар, онцлог шинж, сурах хүсэл эрмэлзлийг нь хүндэтгэн үзэж бүх нийтэд чанартай боловсрол олгоход чиглэсэн үйл явц билээ.

Цаашид боловсон хүчний хүрэлцээ хангамжийг нарийн судлах, тухайн багш бэлтгэдэг их дээд сургуулиудын чанарт онцгой анхаарах, тусгай хэрэгцээт боловсрол олгох чиглэлийн багшлах боловсон хүчинг бодлогоор бэлтгэх, мэргэжлийн сэтгэл судлаачдыг ажиллуулах, боловсролын хөтөлбөрийг эргэн харж хүүхдийн сурах сонирхолд хөтөлсөн дарамт шахалт, даалгавар багатай хөтөлбөрт шилжих, эцэг эхийн оролцоо, үүрэг хариуцлагыг шинэ түвшинд гаргах нь нэн чухал байна.



1 БСШУСЯ, АХБ, Тэгш хамруулах боловсролыг дэмжих нь төсөл. Судалгааны тайлан. УБ. 2019

ТАВ. ХАВСРАЛТУУД

ХАВСРАЛТ 1. БАРИМТ БИЧГИЙН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ АРГАЧЛАЛ

НЭГ. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

“Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвсэл “Хүүхдийн сурч боловсрох эрхийн хэрэгжилт, тэдэнд тулгарч буй саад тотгорыг тодорхойлох зорилгоор энэхүү суурь судалгааг явуулж байна.

Энэхүү судалгаа нь нийгмийн маргиналчлагдсан бүлгийн хүүхдийн боловсролын хүртээмжийн асуудлаар мэргэжилтэн, эцэг эх, сурагчдын дунд хийж буй сэдэвчилсэн, чанарын судалгаа бөгөөд тухайн судалгааг зөвлөх судлаачтай хамтран гүйцэтгэж байгаа юм.

ЖИЧ: Судалгаанд оролцогчийн өгсөн мэдээллийг Монгол Улсын хувь хүний нууцыг хадгалах хуулийн дагуу чандлан хадгална.

ХОЕР. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- Баримт бичгийн шинжилгээг сонгон авсан талбараас мэдээлэл цуглуулахад ашиглана.
- Судалгаанд хэрэглэх нэр томъёоны үндсэн тодорхойлолттой(маргиналчлагдсан бүлэг¹, эмзэг бүлэг²) танилцаж, тайлбарлах мэдлэг, чадвартай болсон байна.
- Судлаач мэргэжилтэн, төрийн байгууллагаас холбогдох статистик, бодлогын баримт бичгийг хуулбарлаж авах буюу тэмдэглэл хийсэн байна.

ГУРАВ. СУДАЛГААНЫ ХҮРЭЭНД ЦУГЛУУЛАХ ТООН МЭДЭЭЛЭЛ

Судлаач дараах хүснэгтийг ашиглан судалгаанд хамрагдаж буй талбарын тоон мэдээллийг 2019 оны 12 сарын байдлаар авч, тэмдэглэн, нотолгоо бүхий баримт бичгийг хуулбарлаж, хавсаргана.

- 1 Нийгмийн тэгш бус байдлаас үүдэлтэйгээр урт хугацаанд гадуурхагдаж, боловсролын бодлого, төсөвлөлтийн хийдлээс сурч боловсрох эрх нь зөрчигдсөн бүлэг.
- 2 Алслагдсан сум дүүрэг, хороодын нийгэм-эдийн засгийн статусын хувьд эмзэг байдалд байгаа амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой өрхөд амьдарч буй хүүхдүүд

№	Агуулга	2019	Нотолгоо баримт бичгийг хавсаргах
1	Ерөнхий боловсролын сургуулийн тоо		Шаардлагагүй
2	ЕБС-ийн сурагчдын тоо, хүйсээр		Хавсаргаж болно
3	Сургуульд суралцдаггүй хүүхдийн тоо		Шаардлагатай
4	Сургууль завсардсан хүүхдийн тоо		Шаардлагатай
5	Эмзэг бүлгийн өрхөд амьдардаг буюу хяналтад байдаг хүүхдийн тоо		Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд..... Үндэстний цөөнх..... ЖСХ, үе тэнгийн дээрэлхэлтийн хохирогч..... Алслагдсан сум, хороодын НЭЗ-ийн хувь эмзэг өрхөд амьдарч буй.....
6	Боловсролын үйлчилгээнд тэгш хамруулах чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, төлөвлөгөө/ дотоод ба гадаад орчин/		Шаардлагатай
7	Төсөв, санхүүжилт/орчин болон багшийг урамшуулах/		Шаардлагатай
8	Хүндрэл бэрхшээлийг тодорхойлсон судалгаа болон нөлөөллийн ажлууд байгаа эсэх		Шаардлагатай
9	Хамтран ажилладаг, оролцогч талууд бий эсэх		Хавсаргаж болно
10	Сургуульд буцааж оруулсан кейс тохиолдол бий эсэх		Шаардлагатай

ДӨРӨВ. СУДАЛГААГ ДУУСГАХ

Судалгааны мэдээлэл бүрэн дүүрэн цугласан эсэхийг судлаач шалгаж үзнэ. Эргэлзээтэй, тодруулбал зохих мэдээллийг холбогдох мэргэжилтнээс лавлах шаардлагатай.

Судлаач мэдээлэл цуглуулсны дараа баримт бичгийн шинжилгээний үр дүнг тэмдэглэж, word, excel программ дээр сийрүүлж бичнэ. Зөрчилтэй, харилцан адилгүй хариултыг тусгайлан цаасан дээр тэмдэглэж, дүгнэн, нэгдсэн ойлголттой болсны дараагаар тухайн талбарын мэдээллийг компьютерт оруулахыг анхаарна уу!

ТАНД АМЖИЛТ ХҮСЬЕ.
СУДАЛГААНЫ БАГ

ХАВСРАЛТ 2. МЭРГЭЖИЛТНЭЭС АВАХ СТАНДАРТ ЯРИЛЦЛАГЫН АСУУЛТЫН ЧИГЛЭЛ

“Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвслээс “Хүүхдийн сурч боловсрох эрхийн хэрэгжилт, тэдэнд тулгарч буй саад тотгорыг тодорхойлох зорилгоор энэхүү суурь судалгааг явуулж байна.

Тухайн судалгааг МУИС-ийн зөвлөх багштай хамтран гүйцэтгэж байгаа юм. Энэхүү судалгаа бол эмзэг бүлгийн өрхөд амьдарч буй хүүхдийн боловсролын хүртээмжийн асуудлаар мэргэжлийн хүмүүсийн дунд хийж буй сэдэвчилсэн, чанарын судалгаа юм.

ЖИЧ: Судалгаанд оролцогчийн өгсөн мэдээллийг Монгол Улсын хувь хүний нууцыг хадгалах хуулийн дагуу чандлан хадгална.

Мэргэжилтэнтэй хийх стандарт ярилцлагын удирдамж (ЕБС-ийн НА, Боловсролын хэлтсийн мэргэжилтэн, ГБХЗХГ гм)

Ярилцлагын тэмдэглэлийн дугаар:

Ярилцлага хөтөлсөн судлаач:

Ярилцлага хийсэн огноо:

А. Ярилцлагад оролцогчийн хувийн мэдээлэл

1. Аймаг, дүүрэг
2. Сум, хороо
3. Таны ажиллаж буй салбар
4. Таны нас
5. Таны хүйс
6. Таны боловсрол
7. Таны мэргэжил
8. Таны ажиллаж буй албан тушаал, зэрэглэл
9. Таны ажилласан туршлага хэдэн жил болж байгаа вэ?

Б. Бүлэг асуултууд

1. Та өөрийн ажиллаж буй салбар, ажил мэргэжлийн онцлог, туршлагын талаар танилцуулна уу?
2. Танай аймаг, дүүрэг, орон нутгийн боловсролын салбарт ямар асуудал тулгамдсан шинжтэй байдаг вэ?
3. Хүүхдүүд ЕБС-д хамрагдалтын түвшин хэр хэмжээнд байдаг вэ?
4. ЕБС-ийн хүүхдүүдийн хувьд сургууль завсардах тохиолдол гардаг уу?,
5. ЕБС-д огт суралцдаггүй хүүхдүүд хэчнээн байдаг вэ?, энэ нь юунаас ихэвчлэн хамаарч байна вэ?

6. Маргиналчлагдсан эмзэг бүлгийн хүүхдүүдийн боловсрол эзэмшихэд тулгарч буй саад тотгор, сорилт бэрхшээлийн талаар өөрийн санал бодлоо илэрхийлнэ үү?
7. Тухайн орон нутагт амьдарч буй хүүхдүүд боловсрол эзэмшихэд ихэвчлэн ямар саад бэрхшээл тулгарч байна вэ?, бүлэг бүрд тохиолдож буй саад тотгор, сорилт бэрхшээлийг нэг бүрчлэн дурдана уу?

Эмзэг бүлгийн хүүхдүүд	Төрөл хэлбэр	Яг ямар саад тотгор, сорилт бэрхшээлүүд тулгарч байна вэ?
1.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд “Хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэдэгт бие мах бодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан ¹ , 18 хүрээгүй хүн бүрийг ² хамруулж ойлгоно.	Хөгжлийн бэрхшээлийн дараах төрлүүд байдаг. 1.Харааны бэрхшээл 2.Ярианы бэрхшээл 3.Сонсголын бэрхшээл 4.Хөдөлгөөний бэрхшээл 5.Сэтгэцийн бэрхшээл 6.Хавсарсан бэрхшээл	
2.Үндэстний цөөнхийн бүлгийн хүүхдүүд	Казак хүүхдүүд Тува хүүхдүүд	
3.Жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогч хүүхдүүд/тодорхойлолт/ Жендэрт суурилсан хүчирхийлэл гэж жендэрээс үүдэлтэйгээр бусдад бие мах бодь, сэтгэл санааны гэм хор, эдийн хохирол учруулсан, учруулж болзошгүй үйлдэл, эс үйлдэхүйг ³ хэлнэ.	ЖСХ-ийн хэлбэрүүдэд: 1.Гэр бүлийн хүчирхийлэл 2.Ураг төрлийн хүчин 3.Болзооны үеийн хүчин 4.Гудамж, олон нийтийн газар үйлдэгдэж буй хүчин 5.Бэлгийн мөлжлөг буюу хүчээр биеийг нь үнэлүүлэх 6.Бэлгийн халдлага, 7.Бэлгийн дарамт, халдлага 8. Үе тэнгийн дээрэлхэлт, дарамт 9.Хүн худалдаалах зэрэг хүчирхийлэл, гэмт хэрэг	

1 Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль. 4.1.1. УИХ. 2016

2 Хүүхдийн эрхийн тухай конвенц. 1.1-р зүйл. 1989

3 Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль. 4.1.8-р зүйл. УИХ. 2011

4.Алслагдсан сум дүүрэг, хороодын нийгэм-эдийн засгийн статусын хувьд эмзэг байдалд байгаа амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур ⁴ орлоготой өрхөд амьдарч буй хүүхдүүд	Сургууль гэр хоорондын зай, байршлын хувьд алслагдмал байдал Мөнгө санхүүгийн хувьд: Хоолны зардал, унааны зардал, дүрэмт хувцасны зардал, гм	
---	--	--

8. Танай аймаг, дүүрэгт тухайн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр ямар нэгэн бодлого, хөтөлбөр хэрэгжүүлдэг үү, хэрэв тийм бол дурдана уу?
 - А.Засаг даргын бодлого, мөрийн хөтөлбөрт/агуулгыг тэмдэглэх/
 - Б.ИТХ-ын бодлого, үйл ажиллагаанд/агуулгыг тэмдэглэх/
 - В.Өөр ямар нэг байгууллагаас/агуулгыг тэмдэглэх/.....
9. Тухайн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр төсөв санхүү байдаг уу?(орон нутгийн төсөвт, донор байгууллагын санхүүжилтээр, эсвэл төсөл хөтөлбөрийн гм), хэрэв байдаг бол юунд ихэвчлэн зарцуулдаг вэ?
10. Аймаг дүүрэг, сум орон нутгийн хувьд хүүхдийн сурч боловсрох эрхийн хэрэгжилтийг хангах талаар ямар бодлого хэрэгжүүлж, хэрхэн ажиллах шаардлагатай гэж үзэж байна вэ?

4 Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох тухай хууль. 5-р зүйл. УИХ.1998. Хэрэглээний доод хэмжээг тогтоосон түвшин Улаанбаатар-230.0, Хангайн бүс-206.0, Баруун бүс-203.4, Зүүн бүс-201.7, Төвийн бүс-198.3 мянган төгрөгөөр 2020 онд ҮСХ-ноос шинэчлэн тогтоосон.

- Б5.2.1. Цэцэрлэгийн насны [.....]
- Б5.2.2. Сургуульд суралцдаг [.....]
- Б5.2.3. Сургуулиас завсардсан [.....]
- Б5.2.4. Гэрээсээ тусдаа амьдардаг [.....]
- Б5.2.5. Хөгжлийн бэрхшээлтэй [.....]
- Б5.2.6. Хөдөлмөр эрхэлдэг [.....]
- Б5.2.7. Хүчирхийлэлд өртөж байсан [.....]
- Б5.2.8. Мансуурах, донтох эрсдэлд буй [.....]
- Б5.2.9. Гэмт хэрэгт холбогдож байсан [.....]

Б6. Танай өрхийн сарын дундаж орлого/төгрөгөөр, тоогоор бичих/
[.....]

Б7. Өрхийн орлогын эх үүсвэр/хэдэн ч хариулт өгч болно/

1. Цалин
2. Түрээсийн ашиг
3. Бизнес, наймааны орлого
4. Өрхийн аж ахуй/мал, ногоо, туслах аж ахуй/
5. Зээлдүүлсэн болон хадгаламжийн хүүгийн орлого
6. Мөнгөн тусламж /гадаадаас гуйвуулсан мөнгө гм/
7. Тэтгэвэр, тэтгэмж
8. Хамаатан садны дэмжлэг туслалцаа
9. Хүүхдийн тэтгэмж
10. Өөр/бичих.....

Б8. Хүүхдийн сургуульд завсардсан буюу боловсролоос тусгаарлагдах үндсэн шалтгаан юутай холбоотой байсан бэ?

1. Хүүхдийн хөгжлийн бэрхшээл
2. Өрхийн байршил, амьжиргааны нөхцөл
3. Жендэрт суурилсан хүчирхийлэл
4. Үндэстний цөөнх
5. Өөр/бичнэ/.....

Б9. Тухайн хүүхэд айлын хэд дэх хүүхэд вэ?

- Айлын том хүүхэд
- Айлын дунд хүүхэд
- Айлын бага хүүхэд
- Айлын ганц хүүхэд
- Бусад [.....] бичнэ үү.

Б10. Тухайн хүүхэд хөдөлмөр эрхэлдэг эсэх

1. Тийм
2. Үгүй

В. ХҮҮХДИЙН БОЛОВСРОЛООС ТУСГААРЛАГДАХ ШАЛТГААН, БЭРХШЭЭЛ

В1. Таны бодлоор Хүүхдийн суралцах, боловсрол эзэмшихэд юу саад болж байна вэ?

		Маш их	Их	Дунд	Бага	Огт үгүй
1	Тусгай хэрэгцээ/хөгжлийн бэрхшээл/	5	4	3	2	1
2	Хэл, соёлын бэрхшээл	5	4	3	2	1
3	Байршил, алслагдсан байдал	5	4	3	2	1
4	Ядуурал, амьжиргааны түвшний дорой байдал	5	4	3	2	1
5	Мөнгө санхүүгийн бэрхшээл	5	4	3	2	1
6	Мал маллах	5	4	3	2	1
7	Ажил хөдөлмөр эрхлэх	5	4	3	2	1
8	Хурдан морь унах/унаач хийх	5	4	3	2	1
9	Ялгаварлан гадуурхал	5	4	3	2	1
10	Жендэрт суурилсан хүчирхийлэл	5	4	3	2	1
11	Гэрийн ажил (дүүгээ харах, газар тариалан, өрхийн үйлдвэрлэлд туслах гм)	5	4	3	2	1
12	Өөр ямар.....	5	4	3	2	1

В2.Танай хүүхэд суралцах, боловсрол эзэмшихэд соёл, хандлага, туршлага, материаллаг орчин гм-ийн хувьд ихэвчлэн ямар саад тотгор, сорилт бэрхшээл тулгарч байгаа талаар тодорхой бичнэ үү?

В2.1 Хэрэв хөгжлийн бэрхшээлтэй холбоотой бол чухам аль нь вэ?

	Ямар бэрхшээлтэй/үйлдлийн ямар бэрхшээл болохыг сонгоно уу/	Дутагдаж буй, хэрэгцээт зүйл (Дохионы орчуулагч, тэргэнцэр, анги танхимын суудал, өргөж дийлэхгүй, хүргэж өгөх хүн байхгүй, гм)	Тулгарч буй бэрхшээл, сорилт (Дэд бүтэц, сургуулийн гадаад, дотоод орчин, олон нийт, сургууль, багш, эцэг эх, ангийн хүүхдүүдийн ойлголт, хандлага гм-ээс санаа авч асуух)
1	Харааны бэрхшээл 1.Ойрын хараа муу 2.Холын хараа муу, 3.Нүдний хараа сул учраас шил зүүдэг 4.Шил зүүдэг боловч хардаггүй 5.Өнгө ялгадаггүй 6.Өөр ямар?		

2	Хэл, ярианы бэрхшээл 1.Ээрдэг 2.Гацдаг 3.Хэлгүй 4.Дохионы хэлээр ярьдаг 5.Харилцаа тогтоох чадвар муу 6.Өөр ямар?		
3	Сонголын бэрхшээл 1.Сул сонсдог 2.Дүлий/огт сонсдоггүй 3.Сонголын аппарат зүүх шаардлагатай боловч боломжгүй 4.Бусад		
4	Хөдөлгөөний бэрхшээл 1.Саажилттай 2.Явж чаддаггүй 3.Зогсож чаддаггүй 4.Таягтай 5.Тэргэнцэртэй 6.Хэвтрийн 7.Бусад		
5	Сэтгэц, оюун ухааны бэрхшээл 1.Анхаарлын дутмагшил, хэт хөдөлгөөнтөх эмгэг 2.Тархины гэмтэл 3.Аутизмын хүрээний эмгэг 4.Дауны синдром 5.Сэтгэл түгших, сэтгэц гутрал 6.Бусад		
6	Хавсарсан бэрхшээл (Нэгээс дээш бэрхшээлүүд хавсарч илэрсэн)		

B2.2 Хэрэв өрх гэрийн амьжиргаа, орлогын түвшинтэй холбоотой бол чухам аль нь вэ?

		Дутагдаж буй, хэрэгцээт зүйл (ажил төрөл, тусламж, дэмжлэг, мөнгө гм)	Тулгарч буй сорилт, бэрхшээл (ялгаварлан гадуурхалт, ойлголт, хандлага гм-ээс санаа авч бичнэ үү)
1	Шилжин ирсэн, бүртгэлгүй		
2	Бичиг баримтгүй		
3	Сургуулиас шаарддаг төлбөр хураамж		
4	Дүрэмт хувцас		
5	Сурах бичгийн зардал		
6	Сургалтын төлбөр		
7	Унааны зардал		
8	Хоолны зардал		
9	Хөдөлмөр эрхэлдэг		
10	Гэрийн ажил		
11	Өөр ямар.....		

B2.3 Хэрэв жендэрт суурилсан хүчирхийлэлтэй холбоотой бол чухам аль нь вэ?

	Жендэрт суурилсан хүчирхийлэл	Дутагдаж буй, хэрэгцээт зүйл (ичих, дэмжлэг туслалцаа байхгүй гм)	Тулгарч буй бэрхшээл, сорилт (багш, эцэг эх, сургууль, ангийн хамт олон болон үе тэнгийнхний сөрөг хандлага, ялгаварлан гадуурхал, үл хайхрах байдал гм)
1	Эцэг эхийн дэмжлэг сул, хүүхдээ сургах сонирхолгүй		
2	Эцэг эх архи, мансууруулах бодисын хамааралтай		
3	Хүүхэд төрүүлсэн		
4	Хүүхэд хардаг		
5	Ялгаварлан гадуурхах		
6	Бэлгийн халдлага		
7	Бэлгийн дарамт		
8	Үе тэнгийн дарамт, шахалт, дээрэлхэлт		
9	Бэлгийн мөлжлөгт өртсөн(хүчээр биеийг нь үнэлүүлэх гм)		
10	Хүн худалдаалах		
11	Бусад.....		

B2.4 Хэрэв үндэстний цөөнхийн бүлэгтэй холбоотой бол чухам аль нь вэ?

	Үндэстний цөөнх	Дутагдаж буй, хэрэгцээт зүйл (багш, эцэг эх, сургуулийн дэмжлэг туслалцаа байхгүй гм)	Тулгарч буй бэрхшээл, сорилт (хэл соёлын ялгаа, багшийн мэргэжил дээшлүүлэх байдал, сургуулийн төсөв, анги танхимын суудлын хүрэлцээ гм)
1	Казах хүүхэд 1. Хэл 2. Соёл 3. Сурах бичиг 4. Хос хэлний хөтөлбөр 5. Өөр ямар		
2	Тува хүүхэд 1. Хэл 2. Соёл 3. Сурах бичиг 4. Хос хэлний хөтөлбөр 5. Өөр ямар		

“БҮХ НИЙТ БОЛОВСРОЛЫН ТӨЛӨӨ!” ИРГЭНИЙ НИЙГМИЙН ҮНДЭСНИЙ ЭВСЛИЙН ТУНХАГ

Боловсрол нь хүн бүрийн өдөр тутмын амьдралд, насан турш нөлөөлөх үндсэн эрх, хүний хөгжлийн түлхүүр бөгөөд иргэн бүрт чанартай боловсрол олгох нь төрийн хүлээх гол үүрэг хариуцлага гэдэгт итгэн;

Өнөөгийн тогтолцоонд боловсролыг явцуу тодорхойлдог, хүн бүрийн ялгаатай байдлыг харгалздаггүй, ялгаварлан гадуурхдаг, хангалттай санхүүжилт олгодоггүй зэргээс шалтгаалан бодлого төлөвлөх, хэрэгжүүлэх үйл явцад цогц хандлага дутагдаж; боловсролын тогтолцооны үр өгөөж нь хувь хүний хүсэл тэмүүлэл, нийгмийн эрэлт хэрэгцээнээс асар зөрүүтэй байсаар ирсний улмаас үнэ цэнэтэй амьдарч, амьдралын чанараа дээшлүүлэх боломж олгохгүй байгаад сэтгэл зовнин;

Энэ нь эрх мэдлийн шударга бус бүтцийг бий болгож, тэгш бус байдлыг хадгалж үлдэх арга зам болж байгааг эсэргүүцэн;

Боловсролын чанар, хүртээмж, хариуцлагатай байдлын төлөө хүчээ нэгтгэн ажиллаж, энэ үйл явцад хувь хүн, иргэний нийгмийн байгууллага, бүлгүүдийг өргөнөөр татан оролцуулж, өргөн суурьтай, зохион байгуулалттай, хүчтэй хөдөлгөөн бий болгохыг чухалчлан;

Энэ үйл явцад нийгмийн бүх бүлэг, ялангуяа эрх мэдлийн цөөнхийн оролцоог хангахыг онцлон;

Иргэд, бүлгүүдийн мэдлэг, чадварыг хөгжүүлж, тулгарсан асуудлаа гаргаж ирэх, шийдлийг шаардах, хариуцлага тооцох чадавхтай болоход нь дэмжлэг үзүүлэхийг эрмэлзэн;

Боловсролын тогтолцоог хүний мэдэх, бүтээх, хүний ёсоор хамтран амьдарч, нэр төртэйгээр оршиход суралцахуйц, хувь хүний потенциал, чадвар, чадавхыг нээж, эерэг зан үйл, хандлагыг төлөвшүүлэхэд чиглэгдсэн, хүмүүнлэг, ардчилсан, хүн бүрийн эрхийг хангасан, тэгш хүртээмжтэй болгон өөрчлөхийг эрхэмлэн;

Хүүхэд, эцэг эх, багш, орон нутгийн бүлгүүд болон үндэсний, хэлний, соёлын, бэлгийн цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, орлого багатай иргэд зэрэг дуу хоолойгоо хүргэж, шийдвэр гаргахад оролцож чадахгүй байгаа бүлгүүдийг эрх мэдэлжүүлэх зорилгоор боловсролын тогтолцоо, бодлогод хяналт шинжилгээ, үнэлгээ хийх чадавхыг бүрдүүлэх, нөлөөлөх ур чадвараа дээшлүүлэх шаардлагыг ухамсарлан;

Хүний эрх, жендэрийн тэгш эрх, үл ялгаварлан гадуурхах, хүчирхийллээс ангид, хүлээцтэй байх, нээлттэй, ил тод, хариуцлагатай байх зарчмыг баримтлан;

Монгол улсад боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах, төсвийг хянах, хариуцлага шаардах, бодлогод нөлөөлөх үндэсний кампанит ажил зохион байгуулах зорилгоор эвсэн нэгдсэнээ тунхаглаж байна.

2010 оны 9 сарын 3

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

UIH.MN
СУДАЛГААНЫ САН